



СУДАЛГААНЫ ТАЙЛАН

АВЛИГА БА ЖЕНДЭРИЙН ХОЛБОО ХАМААРЛЫН СУДАЛГАА

“МОНГОЛ УЛСЫН ИНСТИТУЦИЙН ШУДАРГА,
ИЛ ТОД БАЙДАЛ” ТӨСӨЛ



АВЛИГА БА ЖЕНДЭРИЙН ХОЛБОО ХАМААРЛЫН СУДАЛГАА

“МОНГОЛ УЛСЫН ИНСТИТУЦИЙН ШУДАРГА,
ИЛ ТОД БАЙДАЛ” ТӨСӨЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Тус судалгааг Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар, Төрийн Департаментын дэргэдэх Олон улсын хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах товчооны санхүүжилтээр Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын хэрэгжүүлж буй “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал” (2021-2024) төслийн хүрээнд бүтээв.

СУДАЛГААГ БОЛОВСРУУЛСАН:

Н.Болдмаа МУИС-ийн дэд профессор, судлаач

М.Батбаатар МУИС-ийн дэд профессор, судлаач

СУДАЛГААГ ХЯНАСАН:

Н.Одонтуяа ОУЭЗХБ-ын Суурин төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэгч

Л.Түвшинбат Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны дарга, ахлах комиссар

Ц.Бадам Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны ахлах ажилтан, ахлах комиссар

Зохиогчийн эрх@2024. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)
Энэхүү судалгааны агуулга, үзэл бодлыг зохиогчид бие даан боловсруулсан бөгөөд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, түүний гишүүд, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын үзэл бодол, байр суурийг илэрхийлэхгүй болно.

Зохиогчийн эрхийн дагуу хамгаалагдсан. Энэхүү судалгааг сургалтын зорилгоор ашиглах бол албан ёсны зөвшөөрөл авч, эх сурвалжийг дурдсаны үндсэн дээр үнэ төлбөргүй ашиглаж болно. Үүнээс өөр шалтгаанаар олшруулах, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээхийг хориглоно. Дахин хэвлэх бол Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авна.

Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж, Бодь цамхаг, 603 тоот
Улаанбаатар 15160, Монгол Улс
[@IDLOnews](http://www.idlo.int)

АГУУЛГА

ТАЛАРХАЛ.....	6
ХҮСНЭГТ, ДҮРС, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	8
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	10
НЭГ. СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ	12
ХОЁР. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ	15
ГУРАВ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ.....	16
3.1 Судалгааны зорилго, зорилтууд.....	16
3.2 Судалгааны хамрах хүрээ	17
3.3 Мэдээлэл цуглуулсан арга, асуултууд.....	18
3.4 Судалгааны түүвэр.....	20
3.5 Мэдээллийн чанарын хяналт ба шинжилгээ.....	22
3.6 Судалгааны хязгаарлагдмал талууд.....	22
3.7 Судалгааны үр дүнг тархаасан байдал.....	23
3.8 Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл	23
ДӨРӨВ. АВЛИГА БА ЖЕНДЭРИЙН ХОЛБОО ХАМААРЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	28
4.1 Авлига ба жендэрийн суурь нөхцөл байдал.....	28
4.2 Жендэрээс үүдэлтэй авлигын ялгаатай ойлголт, төсөөлөл.....	39
4.3 Жендэрийн ялгаатай байдал ба авлигын талаарх түршлага	46
4.4 Авлигын талаарх жендэрийн ялгаатай хэв шинжүүд.....	51
4.5 Жендэрийн онцлог ба авлигатай үр дүнтэй тэмцэх нь.....	55
ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	60
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	65
ХАВСРАЛТУУД.....	67

ТАЛАРХАЛ

ОУЭЗХБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар АНУ-ын Засгийн газар Төрийн Департаментын дэргэдэх Олон улсын хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах товчооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал төсөл”-ийн хүрээнд Авлига ба жендэрийн холбоо хамаарлын судалгааг МУИС-ийн багш, судлаачдын баг 2024 оны 2 дугаар сараас 6 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэв.

Үнэлгээний тайланг боловсруулахад дэмжлэг үзүүлэн, хамтран ажилласан бүх оролцогч талд талархал илэрхийлье. Түүнчлэн, судалгааны мэдээлэл цуглуулахад дэмжсэн АТГ-ын Судалгаа, шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Л.Түвшинбат, ахлах комиссар Ц.Бадам ба бусад мэргэжилтнүүд, ОУЭЗХБ-ын Суурин төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэгч Н.Одонтуяа, сургалт, логистик хариуцсан мэргэжилтэн Б.Ундрахбуян болон судалгаанд оролцсон төрийн болон хувийн хэвшлийн ажилтнууд, иргэдэд талархал илэрхийлж байна.

Судлаачдын баг

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АТГ	Авлигатай Тэмцэх Газар
АТИ	Авлигын төсөөллийн индекс
АЭХ	Авлигын эсрэг хууль
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
ГХтХ	Гамшгаас хамгаалах тухай хууль
МУ	Монгол Улс
МУИС	Монгол Улсын Их сургууль
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ОУЭЗХБ	Олон Улсын Эрх Зүйн Хөгжлийн Байгууллага
ЖҮХ	Жендэрийн Үндэсний Хороо
ЖЭТБХтХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТББ	Төрийн бүс байгууллага
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБНГУ	Холбооны Бүгд найрамдах Герман Улс
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ЦХХЯ	Цахим Хөгжил Харилцаа Холбооны Яам
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам

ХҮСНЭГТ, ДҮРС, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Судалгааны аргачлал	18
Хүснэгт 2.	Түүврийн тоо хэмжээ	21
Хүснэгт 3.	Санал асуулгад оролцсон иргэдийн мэдээлэл (хүйс, байршил, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар).....	24
Хүснэгт 4.	Ганцаарчилсан ярилцлагад оролцсон эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл.....	25
Хүснэгт 5.	Шүүхээр шийдвэрлэгдсэн авлигын гэмт хэрэг, газар зүйн байршлаар	27
Хүснэгт 6.	Монгол Улсын жендэрийн зөрүүтэй байдлын индекс	34
Хүснэгт 7.	Парламентад суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь	35
Хүснэгт 8.	Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтан ба төрийн захиргааны удирдах албан тушаалтан, 2022-2023 он, хүйсээр.....	36
Хүснэгт 9.	Төрийн захиргааны төв байгууллагын албан тушаалтан, 2023 он, хүйсээр	37
Хүснэгт 10.	Төрийн болон төсөвт байгууллагын нийт ажилтны тоо, 2023 он, судалгааны талбараар	38
Хүснэгт 11.	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын нийт ажилтны тоо, 2023 он, судалгааны талбараар	38
Хүснэгт 12.	Иргэд, олон нийт авлигыг хэрхэн ойлгож байна вэ?	40
Хүснэгт 13.	Таны бодлоор аль салбарт авлига илүү гардаг вэ?/салбарыг үсгийн дарааллаар байрлуулсан/.....	42
Хүснэгт 14.	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гар цайлгалт, албан бүс төлбөрийн хэмжээ . 43	
Хүснэгт 15.	Хэрэв дээрх тохиолдолтой таарч байсан бол энэ нь аль салбарт, ямар хүйсийн хүнд тохиолдож байсан бэ?	44
Хүснэгт 16.	Чухам ямар албан тушаалтан, эсвэл ажилтанд авлига өгч байсан бэ?	46
Хүснэгт 17.	Авлига авч буй албан тушаалтан	47
Хүснэгт 18.	Авлигын мөнгөн дүн, хүйсээр	48
Хүснэгт 19.	Авлигын гэмт хэрэгт холбогдсон иргэдийн нийгмийн дүр төрх.....	50
Хүснэгт 20.	Таны бодлоор дурдсан салбарт гарч буй авлига ямар үр дагавртай вэ?	53
Хүснэгт 21.	Авлигын шалтгаан, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн материалаар	54
Хүснэгт 22.	Авлигатай тэргүүн зэрэгт тэмцэх ёстой байгууллага	56
Хүснэгт 23.	Авлигатай тэмцэх бодлогод жендэрийн онцлогийг харгалзах нь.....	57

Дүрс 1.	Судалгааны ажлын агуулгын хүрээ.....	16
Дүрс 2.	Судалгааны газар зүйн байршил.....	17
Дүрс 3.	Судалгааны мэдээлэл цуглуулалтын арга, оролцогчид.....	19
Дүрс 4.	Судалгааны мэдээлэл цуглуулсан аргуудын үялдаа.....	20
Дүрс 3.	Авлигын төсөөллийн индекс, 2023 он.....	29
Дүрс 4.	Жендэрийн зөрүүтэй байдлын индекс.....	34
Дүрс 5.	Авлигын талаарх ойлголт, төсөөллийн ялгаа.....	41
Дүрс 6.	Эрх бүхий ажилтан, албан тушаалтанд мөнгө эд зүйлс өгөх тохиолдол.....	42
Дүрс 7.	Авлигын талаар санал бодлоо хуваалцах байдал.....	54
График 1.	Авлига аль салбарт илүүтэй гардаг талаар хүйсийн ялгаатай байр суурь...	43
График 2.	Авлига аль салбарт илүүтэй гардаг вэ: хүйсийн ялгаатай байр суурь.....	45
График 3.	Авлигын талаарх түршлага: тохиолдол.....	46
График 4.	Авлигын талаарх түршлага: гар цайлгах буюу хахууль өгөх шалтгаан.....	48
График 5.	Авлигын талаарх түршлага: айдас, болгоомжлол.....	49
График 6.	Авлигын талаар жендэрийн ямар хэв шинжүүд байна вэ?.....	51

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Нэр томьёо	Тайлбар
Авлига	Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход үрвүүлэн ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ (АЭХ-ийн 3.1.1).
Ашиг хонжоо	Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ үрвүүлэн ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг хэлнэ (АЭХ-ийн 3.1.2).
Албан тушаалын эрх мэдлээ үрвүүлэн ашиглах	Албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг хэлнэ (АЭХ-ийн 3.1.3).
Бэлэг	Нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг хэлнэ.
Давуу байдал	Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ үрвүүлэн ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг
Жендэр	Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг; (ЖЭТБХТХ-ийн 4.1.1)
Жендэрийн хэвшмэл үзэл	Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаарх хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлага; (ЖЭТБХТХ-ийн 4.1.3)
Жижиг авлига	Гаалийн татвар, торгууль, татвар, хураамж, үнэлгээ гэх мэтийг нөхөн төлүүлэхтэй холбогдуулан авсан хахуулийг хэлнэ.
Танил тал	Ойр дотно хүмүүс болон танилаараа дамжуулан нөөц, ажлын байр болон бусад ашиг тусыг хуваарилахдаа давуу эрх олох явдал

Том хэмжээний авлига	Ард түмний эрх ашиг, улс орны аюулгүй байдалд заналхийлж, эрх мэдэлтэй хүмүүсийн нарийн зохион байгуулалттай ажиллагаа
Хандив	Нийтийн албан тушаалтан буюу төрийн албан хаагчид тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ.
Хахууль	Мөнгө болон бусад үнэ цэнтэй эд зүйлсийг харилцан ашигтайгаар солилцох буюу шийдвэр гаргах явдал
Шан харамж	Албаны үүргээ зохих ёсоор биелүүлсний төлөө тухайн этгээдийг хувиараа урамшуулан шагнахыг хэлдэг.
Эмзэг байдал	Аюулт үзэгдэл, осолд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөгдөх зэрэг; (ГХтХ-ийн 4.1.6.)

I НЭГ. СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Нэг. Судалгааны арга зүй, ач холбогдол

- Судалгаа нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE), Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын ажиллагааны агентлаг (SIDA) болон “Транспарэнси Интернэшнл” байгууллага жөндөр ба авлигын холбоо хамаарлыг судлах удирдамжийн дагуу холимог судалгааны арга зүйд суурилан хийгдсэн. Судалгааны үндсэн аргууд нь асуулга, хагас бүтэцчилэгдсэн стандарт сурвалжилга, кейс судалгаа, контент анализ ба судалгааны үр дүнгүүдийг нэгтгэн, баталгаажуулж хийснээрээ онцлог юм. Судалгаанд нийт 1584 иргэн, салбарын 16 төлөөлөл, 5 кейс судалгаа, 28 шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн материалуудыг хамруулсан. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг Улаанбаатар хот, Ховд аймаг, Орхон аймаг, Өмнөговь аймаг, Дорнод аймаг зэрэг нийт 5 талбарт зохион байгуулсан.
- Судалгаа нь иргэдийн сайн дурын үндсэн дээр хийгдэж, мэдээллийн нууцлалыг хадгалах, найдвартай байдлыг хангахад судалгааны баг анхаарлаа хандуулсан. Монгол Улсад салбар дундын асуудал болох Авлига ба жөндөрийн холбоо хамаарлыг анх удаа шинжлэх ухааны үндэслэлтэй судлах оролдлогыг хийн цаашид энэхүү чиглэлээр судлаачдыг гүнзгийрүүлэн судлах эхлэлийг тавьсан.

Хоёр. Авлига ба жөндөрийн өнөөгийн нөхцөл байдал

- Баримт бичгийн судалгааны хүрээнд 30 орчим материалуудад дүн шинжилгээ хийж үзэхэд авлига ба жөндөр нь Монгол Улсын хувьд нэн тулгамдсан нийгмийн асуудал болохыг баталж байна. Авлигын төсөөллийн индекс болон Жөндөрийн зөрүүтэй байдлын индекс Ковид-19 цар тахлын дараа нэмэгдэх төлөв ажиглагдан эдгээр асуудал нь мөн чанараараа бие биеэ нөхцөлдүүлж байж болно.
- Авлигын нөхцөл байдлыг салбар бүрээр, үе шаттай судлаагүй байгааг анхаарах шаардлагатай байна. Судалгаанууд ихэвчлэн бизнес, боловсрол, эрүүл мэнд, шүүх, хууль тогтоох байгууллагуудад хийгдсэн ч он цаг тооллын хувьд ялгаатай, үр дүнгүүд гол төлөв тоон илэрхийллээр тайлбарлагдах бөгөөд хүйсээр шинжилгээ хийж, учир шалтгаан, үр дагаврыг гаргах тал дээр учир дутагдалтай байна.
- Боловсрол, эрүүл мэнд, шүүх, хууль тогтоох байгууллага зэрэг авлигад илүү өртөмтгий байгаа салбаруудын хувьд дундаас дээш албан тушаалд эрэгтэй, харин дундаас доош албан тушаалд эмэгтэй зонхилох хандлагатай байгаа нь эрэгтэйчүүд илүү өндөр түвшний авлигад, эмэгтэйчүүд жижиг авлигад илүү өртөмтгий байна. Өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо хангалтгүй байгаа нь авлигын цар хүрээг нэмэгдүүлэхэд нөлөөлж байх талтай.

Гурав. Жөндэрээс үүдэлтэй авлигын ялгаатай ойлголт, төсөөлөл

Авлигын талаарх иргэд, олон нийтийн дунд нэгдсэн төсөөлөлтэй, хүйсийн хувьд эрс ялгаа байхгүй, нэн ойролцоо байна. Гэвч хүйсийн хувьд авлигын талаарх ойлголт, төсөөллийн хувьд бага зэргийн ялгаа ажиглагдсан.

- Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол авлигыг ёс зүйгүй үйлдэл гэдгийг хүлээн зөвшөөрсөн ч авлигыг хүлцэх хандлагатай байна. Гар цайлгах, албан бус төлбөр төлөх, авлига өгөх, хүнд суртлыг багасгах, ажлаа хурдан шуурхай амжуулах зорилгоор авлига өгөх ойлголт, хандлага эрэгтэй, эмэгтэй хүмүүст ойролцоо жинтэй, мөн тааралдаж байснаа баталсан. Эмэгтэйчүүд илүү эрүүл мэндийн салбарт, харин эрэгтэйчүүд бусад салбарт авлига илүү гардаг гэж үзсэн. Практикт эмэгтэйчүүд биологийн онцлогоос шалтгаалан эрүүл мэндийн үйлчилгээг түлхүү авдаг тул аль болох үйлчилгээг чанартай, үр дүнтэй авах үүднээс авлига өгч байгаа нь ийм хариулт өгөхөд нөлөөлсөн байж болно. Боловсролын салбарт авлигыг гол төлөв эмэгтэйчүүд авч байгааг салбарын ажиллах хүчний хүйсийн харьцаатай холбон тайлбарлах нь чухал. Боловсролын салбарын 76.6 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байгаа тул авлигыг эмэгтэйчүүд зонхилон авах хандлага ажиглагдана.
- Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол авлигад 2 дахин их мөнгийг төлдөг. Эмэгтэйчүүд хамгийн ихдээ 7 сая төгрөгийг, эрэгтэйчүүд хамгийн ихдээ 15 сая төгрөгийг өгсөн нь хүйсээс хамаарч ялгаатай болохыг илтгэнэ. Авлигад эрэгтэйчүүд авлигад илүү өртөмтгий байгаа нь судалгааны үр дүнгээр нотлогдож байна.

Дөрөв. Жендэрийн ялгаатай байдал ба авлигын талаарх түршлага

- Судалгаанд хамрагдсан 2 хүн тутмын нэг нь хүйсээс үл хамааран эрх бүхий ажилтан, албан хаагчид мөнгө, эд зүйлс өгөх явдал гарсан байна. Эмнэлгийн удирдах ажилтан, эмч, сувилагч асрагч нарт жижиг бэлгээр гар цайлгах явдал түгээмэл. Иймд эрүүл мэндийн салбар бусад салбаруудтай харьцуулахад хамгийн эрсдэлтэй болохыг баталж байна. Чанарын судалгааны үр дүнгээр боловсролын салбар дахь авлига бүүрч байгааг мэдээллийн систем болон холбогдох эрх зүйн орчин сайжирсантай холбон тайлбарлаж байна.
- Эрэгтэйчүүдийн хувьд нэхсэн, тэгэх ёстой гэсэн тогтсон ойлголт болон асуудлаас зайлсхийхийн тулд өгдөг гэсэн хариулт өндөр байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд өөрөө хүссэн, чирэгдэл ихтэй байдлыг даван туулахын тулд өгсөн байна. Үүнээс үзэхэд тогтсон хандлага, жендэрийн дүр, үүрэг авлига өгөх, авахад нөлөөлж байна.
- Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим системд жижиг авлигын мэдээлэл нээлттэй, харин өндөр түвшний авлигын мэдээлэл хаалттай байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн 28 хэргийн материалуудад дүн шинжилгээ хийж үзэхэд хүйсийн хувьд эмэгтэй, ахимаг насны, гэрлэсэн олон хүүхэдтэй, дээд боловсролтой, төрийн байгууллагад ажилладаг, өмнө нь ял эдэлж байгаагүй иргэн авлигын хэрэгт холбогдож байна. Эрэгтэй хүмүүс улс төрийн эрх бүхий албан тушаалтнуудтай ойр дотно болох эсвэл танил талаараа дамжуулан нөөц, ажлын байр болон бусад ашиг тусыг хуваарилахдаа давуу эрх олж авах явдал нийтлэг байна.

Тав. Авлигын жендэрийн ялгаатай хэв шинжүүд

- Авлига ба жендэр холбоо хамааралтай гэж үзэж байгаа хэв шинж бүхий бүлэг нь жендэрийн ялгаа багсахад дагаад авлига багасна, аль ч салбарт эрэгтэй, эмэгтэй хүний үүрэг хэрэгтэй, эмэгтэйчүүдийн аливаа зүйлд нягт нямбай ханддаг тул хуулийн

дагуу асуудлыг шийднэ гэж үзэж байна. Авлига ба жендэр холбоо хамааралгүй гэж үзэж байгаа хэв шинж бүхий бүлэг нь авлигад хүйс хамаарахгүй, ухамсрын ойлголт, авлигад тогтолцооны гажуудал, хүнд суртал, шунал сэтгэлгээ, албан тушаал, эрх мэдэл нөлөөлдөг. Авлига нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм дэх эрх, үүргийн ялгаатай байдал, байр суурь, оролцоо, хувь хүний ёс зүй хандлага, сэтгэхүйгээс хамаарч бүрэлдэн бий болох онцлог юм.

- Эрэгтэй хүмүүс улс төрийн эрх бүхий албан тушаалтнуудтай ойр дотно болох эсвэл танил талаараа дамжуулан нөөц, ажлын байр болон бусад ашиг тусыг хуваарилахдаа давуу эрх олж авах явдал нийтлэг байна.

Зургаа. Жендэрийн онцлог ба авлигатай үр дүнтэй тэмцэх нь

- Бүх түвшинд үйлдэгдэж буй авлигыг хэрхэн ойлгож, төсөөлж тодорхойлж байгаагаас хамааран тэдгээрийн авлигыг үл тэвчих, тэмцэх арга хэлбэр илэрхийлэгдэж байна.
- Авлигатай тэмцэхэд АТГ, УИХ, Хууль Хяналтын байгууллага, Засгийн газрыг хэлж байгаа ч 5 иргэн тутмын нэг нь өөрсдийн оролцоо, олон талт байдлыг хангахын чухлыг иргэд онцолж байв. Иргэн бүр авлигыг үл тэвчих ухамсартай, хариуцлагатай байх нь эл үзэгдлийг хязгаарлах нэг хүчин зүйл байж болох юм.

I ХОЁР. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ

Монгол Улсад авлигын нөхцөл байдал өндөр байгаа нь улс төрийн бодлого, эдийн засаг, хувь хүний үхамсар, зэрэг нийгмийн олон хүчин зүйлээс хамаардаг болохыг энэ чиглэлээр хийгдсэн судалгааны тайлангуудад дурджээ. ХБНГУ-ын Берлин хотод төвтэй “Транспарэнси Интернэшнл” байгууллага нь Авлигын төсөөллийн индексийг 180 улс орон, бүс нутгийн нийт салбар (төрийн) дахь авлигын төсөөллийг тэг (их авлигатай)-ээс зүү (маш цэвэр) хүртэлх оноогоор үнэлж эрэмбэлдэг болно. Монгол Улсын авлигын индексийг сүүлийн 3 жилээр үзэхэд 2021 онд 110 дугаарт, 2022 онд 116 дугаарт, 2023 онд 121 дүгээр орж байгаа нь авлига өссөн үзүүлэлт харагдаж байна¹. Авлигатай тэмцэхэд чиглэсэн олон талт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн ч өсөх хандлагатай байгаа нь судлаачдын анхаарлыг татаж байна. Авлигын шалтгааныг технологи, нийгмийн хүчин зүйл, байгалийн хүчин зүйл, эдийн засаг, ёс суртахуун болон хуулийн зохицуулалтыг нийлмэл цогц байдлаар авч үзэхийг чухалчилдаг. Учир нь эдгээр хүчин зүйлүүд нь нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлж байдагт оршино.

Онолын үүднээс авч үзвэл Олон түмний сонголтын онолоор авлига хувь хүний бодож боловсруулсан шийдвэр; Ялзарсан алимын онолоор авлига хүний сөрөг зан үйлээс үүдэлтэй; Зөрчилдөөний онолоор нийгмийн тодорхой үнэт зүйл, хэм хэмжээ нь хүний үнэт зүйл, хэм хэмжээнд нөлөөлж, улмаар албан тушаалтнуудын зан үйл, ёс суртахуунд нөлөөлдөг; Төрийн удирдлагын чиг баримжааны онолоор албан тушаалтнууд зөвхөн чиг үүргээ гүйцэтгэхэд анхаарснаас шударга, ёс зүйтэй байдал алдагдаж, улмаар авлигад автагддаг гэж үзжээ². Эндээс үзэхэд авлигын нөхцөл шалтгааныг хүний боломж, ашиг сонирхол, сэдэл гэж тайлбарлаж болохоор байна. Үүнээс авлигын шалтгааныг хувь хүний түвшнээс гэр бүл, байгууллага, институци, соёлын түвшин хүртэл мөшгөж судлах нь илүү ач холбогдолтой байж болох юм. Авлигад хүйсээс хамаараад ялгаатай ханддаг эсэх, авлигад хүний зан үйл, хэвшмэл үзэл нөлөөлдөг эсэх, авлигад жендэрийн дүр, үүрэг холбоотой эсэх гэх мэт олон талт асуудлууд урган гарч байна.

Олон улсын хэмжээнд энэ сэдвээр цөөнгүй судалгаанууд хийгдсэн ч Монгол Улсад авлига ба жендэрийн холбоо хамаарлыг судалсан судалгаа, шинжилгээний ажлууд дутмаг, мэдээ мэдээлэл хязгаарлагдмал байна. Авлига ба жендэрийн холбоо хамаарал, олон нийтийн ойлголт, хандлага, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн авлигын хэрэгт холбогдож буй ялгаатай байдал, түүний шалтгаан, цар хүрээ, хэлбэр зэрэг асуудлуудыг жендэрийн мэдрэмжтэй байдлаар шинжлэн дүгнэснээр авлигаас урьдчилан сэргийлэх стратеги болон соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг сайжруулахад чухал ач холбогдолтой юм. Иймд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил, менежментийн оновчтой бодлогыг тодорхойлох зорилгоор Авлига ба жендэрийн холбоо хамаарлын судалгааны ажлыг гүйцэтгэв.

1. Transparency International. (2024 оны January 30). **Corruption perception index 2023**. https://images.transparencycdn.org/https://images.transparencycdn.org/images/Report_CPI2023_Eng.pdf

2. АТГ, (2018). **Авлигын шалтгаан, үр дагавар**. <https://cdn.greensoft.mn/uploads/site/1152/files/6e396b8e-a4cd-41d6-8a42-535892425542/Avligiin%20shaltgaan,%20hor%20hunul.pdf>

I ГУРАВ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

3.1 Судалгааны зорилго, зорилтууд

Судалгаа нь авлигын хамрах хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөл, эрсдэл, үр дагавар, авлига ба жендэрийн холбоо хамаарал, авлига дахь жендэрийн үйлдэгдэж буй хэв шинжийг харуулахыг зорив. Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллав.

- Энэ чиглэлээр хийгдсэн ижил төстэй дотоод, гадаадын судалгаа, баримт бичиг, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх;
- АТГ-ын Судалгаа, шинжилгээний алба болон ОУЭЗХБ-ын Хөтөлбөрийн менежертэй зөвшилцөн судалгааны хүрээ, арга зүй, баримт бичиг болон ярилцлагын удирдамж, асуумжийг боловсруулах;
- Авлига ба жендэрийн холбоо хамаарал, авлига дахь жендэрийн үйлдэгдэж буй хэв шинжийг илрүүлэх зорилгоор тоон болон чанарын судалгааг хийх;
- АТГ-ын Судалгаа, шинжилгээний албатай хамтран үүлзалт, хэлэлцүүлэг хийх, мэдээлэл цуглуулах, судалгааны тайлан боловсруулах ажлуудыг гүйцэтгэх зэрэг болно.

Дүрс 1. Судалгааны ажлын агуулгын хүрээ



3.2 Судалгааны хамрах хүрээ

Улаанбаатар хот, баруун бүсээс Ховд, зүүн бүсээс Дорнод, төвийн бүсээс Орхон, Өмнөговь аймгууд багтаж байна. Орон нутгаас байршлын хувьд аймгийн төвд судалгааг гүйцэтгэсэн. Асуулга судалгаанд нийслэлийн 9 дүүрэг, дөрвөн аймгийн нийт 1584 иргэн хамрагдсан байна. Харин чанарын судалгаанд 14 төрийн болон ААНБ төлөөлөлтэй ярилцлага, 25 кейс судалгааг хийсэн.

Насны хязгаар. Тус судалгаанд 18 ба түүнээс дээш насны иргэдийг хамруулахаар зорив.

Газар зүйн хамрах хүрээ. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг зорилтот 4 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулав.

Дүрс 2. Судалгааны газар зүйн байршил



Эх сурвалж: <https://mn.maps-mongolia.com/> Монгол-улсын-газрын-зураг-тойм

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг дараах 5 үндсэн салбарыг хамруулан хийсэн. Үүнд:

- Банк, санхүүгийн салбар
- Боловсролын салбар
- Бизнесийн салбар (уул уурхайн болон барилгын салбар)
- Шүүх, хууль хяналтын байгууллага
- Эрүүл мэндийн салбараас тус тус хамрагдсан.

Эдгээр салбарууд нь төрийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарууд бөгөөд өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд авлигын тархалт, хэмжээ ихээхэн өндөр байсан юм.

3.3 Мэдээлэл цуглуулсан арга, асуултууд

Судалгааны аргачлал нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)³, Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын ажиллагааны агентлаг (SIDA)⁴ болон “Транспарэнси Интернэшнл” байгууллага⁵ жендэр ба авлигын холбоо хамаарлыг судлах удирдамжид суурилсан болно.

Хүснэгт 1. Судалгааны аргачлал

№	Судалгааны нэр	Он	Судалгаа хийсэн газар	Арга зүй
1	Жендэр ба авлига: Бид юуг мэдэж байна вэ? Хэлэлцүүлэгийн баримт бичиг (Gender and Corruption: What do we know? A discussion paper)	2021	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (Organization for Security and Co-operation in Europe /OSCE/)	Баримт бичгийн шинжилгээ, фокус бүлгийн хэлэлцүүлэг (Document review, focus group discussion)
2	Жендэр ба авлига сэдвийн удирдамж (Gender and Corruption topic guide)	2016	“Транспарэнси Интернэшнл” байгууллага (Transparency international)	
3	Жендэр ба Авлига (Gender and Corruption)	2015	Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын ажиллагааны агентлаг: Жендэрийн хэрэглэгдэхүүний багц (Sida: Gender tool box [brief])	Асуулга (Questionnaire)


Авлига ба жендэрийн холбоо хамаарлын судалгаа нь тоон болон чанарын мэдээлэл цуглуулалтын аргуудад үндэслэж явагдав. Тоон судалгааны хүрээнд баримт бичгийн шинжилгээ, асуулгын арга, харин чанарын судалгаанд хагас бүтэцлэгдсэн стандарт сүрвалжилга, кейс судалгаа, контент анализын аргыг ашиглав.

3. Transparency International-Mongolia. (2020 оны May). Mining, Corruption and gender inclusivity in Mongolia. <https://www.osce.org/files/f/documents/4/6/507569.pdf>

4. Sida. (2015). Gender tool box [brief]: Gender and Corruption, <https://cdn.sida.se/publications/files/-gender-and-corruption.pdf>

5. Janna Rheinbay, Marie Chêne . (2016). Gender and Corruption topic guide. <https://knowledgehub.transparency.org/guide/guide-3/download>

Дүрс 3. Судалгааны мэдээлэл цуглуулалтын арга, оролцогчид



Тоон мэдээлэл цуглуулалтын зорилго нь авлига ба жендэрийн суурь нөхцөл байдал, иргэдийн авлигын ойлголт, төсөөлөл, авлигын талаарх түршлага, авлигын жендэрийн хэв шинжүүдийг тодорхойлох зорилготой. Чанарын мэдээлэл цуглуулалтын зорилго нь байгууллагын авлигатай тэмцэж буй өнөөгийн байдал, авлигын холбогдогч, шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс, авлига үйлдэгдсэн арга зам, хэргийн шийдвэрлэлт, авлига ба жендэрийн холбоо хамаарал, үр дагаврыг судлав.


Баримт бичгийн шинжилгээний арга. Энэхүү судалгааны аргыг нэгэнт бий болсон баримт, мэдээ, хууль эрх зүйн баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө, үндэсний болон олон улсын тайлан материалд дүн шинжилгээ хийх зорилгоор ашигласан болно. Баримт бичгийн судалгааны хүрээнд байгууллагын статистик тоо баримтууд, судалгааны анхдагч мэдээлэлтэй танилцсан судлаач нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Статистикийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу хэрэгт авагдсан нотлох баримтууд болон хувь хүмүүсийн мэдээллийг чандлан хадгалах үүрэгтэй. Судалгааны үр дүнг энэхүү судалгаанаас өөр ямар нэгэн зорилгоор ашиглаагүй болно. Баримт бичгийн судалгааны аргын хүрээнд тухайн чиглэлээр бүртгэл дүн шинжилгээ хийж буй байгууллагын өргөдөл, гомдлын мэдээлэл, шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийхээр төлөвлөсөн боловч энэ чиглэлийн хүйсээр ялгасан баримт гарсангүй.

Асуулгын арга. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хүн ам зүйн ерөнхий мэдээллийг тодруулсан ба нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, гэрлэлтийн байдал, боловсрол, ажил эрхлэлт, албан тушаалын зэрэглэл, орлого, орлогын хүрэлцээ зэрэг нийт 11 үзүүлэлтийг ашигласан. Авлигын ойлголт, төсөөллийг тодорхойлохдоо нийт 3 бүлэг, 15 асуултыг ашигласан болно. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг Банк, санхүүгийн салбар, Боловсролын салбар, Бизнесийн салбар (уул уурхайн болон барилгын салбар), Шүүх, хууль хяналтын байгууллага, Эрүүл мэндийн салбар зэрэг таван үндсэн салбарыг хамруулсан. Иргэдийн өгсөн мэдээллийн нууцлалыг Монгол Улсын “Статистикийн тухай

хууль” болон “Хувь хүний нууцын тухай хууль”-ийн дагуу чандлан хадгалсан болно. Судалгаанд хамрагдсан иргэдийн нэр, нас, хүйс зэрэг хувийн мэдээллийг судалгааны үр дүнд дурдаагүй.

Хагас бүтэцлэгдсэн стандарт сурвалжилгын арга. Чанарын мэдээллийг хувь хүнтэй, урьдчилан бэлтгэсэн тодорхой асуултын дагуу дэлгэрүүлэн ярилцаж цуглуулдаг. Судлаач нь оролцогчид судалгааны талаарх мэдээллийг өгөх, мөн судалгаа эхлэхийн өмнө оролцогчийн зөвшөөрлийг заавал авсан байна. Сурвалжилга 50-60 орчим минут үргэлжилнэ. Судлаач нь ярилцлагад оролцож буй иргэнд “Таны өгсөн бүх мэдээллийн нууцлалыг Монгол Улсын Статистикийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу чандлан хадгалах болно. Судалгааны үр дүнг энэхүү судалгаанаас өөр ямар нэгэн зорилгоор ашиглахгүй болно. Таны нэр, нас, хүйс зэрэг хувийн мэдээлэл тань судалгааны үр дүнд дурдагдахгүй болно. Таны хариултууд нууцлагдах тул асуултуудад чин шударгаар, бүрэн гүйцэд хариулах”-ыг тайлбарлаж өгсөн юм.

Дүрс 4. Судалгааны мэдээлэл цуглуулсан аргуудын үялдаа



Кейс судалгааны арга/дизайн. Авлигын асуудалд холбогдож байсан тодорхой тохиолдлыг судлах арга болно. Авлигын талаарх ямар нэг жишээ, эсвэл цөөн тооны өөр хоорондоо үялдаатай “кейс”-ийн талаар нарийвчилсан гүнзгий мэдлэг бий болгоход чиглэдэг чанарын арга юм. Сонирхол татаж буй нэг нөхцөл байдал, хувь хүн эсвэл бүлгийг жишээ болгох, тэрхүү жишээг орчин нөхцөлд нь судлах, ажиглалт, ярилцлага, баримтын шинжилгээ гэх мэт мэдээлэл цуглуулах олон аргыг ашиглан мэдээлэл цуглуулдаг. Кейс судалгааны хүрээнд авлига чухам хаана үйлдэгдэж байна, авлигатай ямар байгууллага, институтэд ажиллаж буй хэн холбогдож байна, тухайн үйлдэл хэдэн удаа давтагдаж байгаа болон хэрхэн энэхүү үйлдэл цаашид өрнөж байгаа болон яагаад ийм зүйл болсон талаар гүнзгийрүүлэн шүүн тунгаах боломжтой.

3.4 Судалгааны түүвэр

Түүврийн хүрээ. Энэхүү судалгааны гол зорилго нь авлига ба жендэрийн холбоо хамаарал, авлига дахь жендэрийн хэв шинжийг харуулахад чиглэсэн гүнзгийрүүлсэн мэдээллийг цуглуулахыг зорьж буйгаараа онцлогтой. Иймд тус судалгаанд их

хэмжээний түүврийг хамруулах нь ач холбогдол багатай тул судалгааны баг зорилтот бүсээс төлөөлөл болгон 5 байршилд мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулав. Үүнд: Улаанбаатар хот, баруун бүсээс Ховд, зүүн бүсээс Дорнод, төвийн бүсээс Орхон, Өмнөговь аймгууд багтаж байна. Орон нутгаас байршлын хувьд аймгийн төвд судалгааг гүйцэтгэв.

Тоон судалгаа: Судалгааны гол зорилго нь илүү нарийвчилсан, асуудлыг тайлбарлахуйц мэдээлэл цуглуулах тул дараах түүврийн хэмжээ болон форматыг судалгаандаа хамруулсан. Судалгааны үр дүнг зөвхөн зорилтот аймаг, дүүргийн түвшинд төлөөлөхүйц байдлаар боловсруулав.

Түүврийн тооцоолол: Тодорхой нэг нутаг дэвсгэр эсвэл хүн амын тодорхой бүлгийн хувьд 2 үе шаттай түүвэр судалгааны түүврийн хэмжээг дараах томъёоллын дагуу тооцов. Үүнд:

$$n = \frac{Z^2 \times P_0 \times (1-P_0)}{e^2} * rr$$

z = хүсэж буй ач холбогдлын түвшинг тодорхойлсон статистик утга

P_0 = түлхүүр үзүүлэлтийн тооцоо (хувийн жин)

e = алдааны хязгаар

rr = асуулгад хариулахгүй байх байдлаар засварлагч

z – 95 хувийн ач холбогдлын түвшин дэх t статистикийн тархалтын утга 1.96

P_0 – түлхүүр үзүүлэлтийн хувийн жин төсөөллөөр 0.5 байхаар таамаглав

e – таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авдаг бидний судалгаанд 5 хувь, итгэх түвшнийг 95 хувь байхаар тооцоолов.

rr – Судалгааны хувьд хариултын түвшинг 90% буюу хариулт өгөхгүй байх түвшинг 10% байхаар авав. Тиймээс уг судалгааны хувьд $rr=1.1$ байхаар авав.

Хувьсагчдын утгыг дээрх байдлаар тодорхойлж, түүврийн хэмжээг тооцоход зохимжит түүврийн хэмжээ нийт 5 байршлаас 1584 хүн амыг судалгаанд хамруулахаар тооцогдов.

Хүснэгт 2. Түүврийн тоо хэмжээ

#	Аймаг/дүүрэг	Асуулга	Ганцаарчилсан ярилцлага	Кейс
1	Нийслэл	784	6	3
2	Орхон аймаг	200	2	---
3	Өмнөговь аймаг	200	2	1
4	Ховд аймаг	200	2	1
5	Дорнод аймаг	200	2	---
	Нийт	1584	14	5

3.5 Мэдээллийн чанарын хяналт ба шинжилгээ

Мэдээллийн чанарын хяналт ба шинжилгээ. Судалгааны баг нь мэдээлэлд гарч болох асуудлыг илрүүлж, бүртгэл хөтлөх улмаар тухайн алдааг засаж, залруулах байдлаар ажиллав. Талбараас ирсэн тоон мэдээллүүдэд өдөр тутам агуулгын хяналтыг хийв. Судалгааны санал асуулгын хувьд дараах агуулгаар, үндсэн гурван бүлэг асуултыг тавьж, хэмжих үзүүлэлтийн найдвартай байдалд дүн шинжилгээ хийсэн.

- Авлигыг хэрхэн ойлгож байна вэ? (Бодол 5, төсөөлөл-5, тохиолдол-5 үзүүлэлт Cronbach alpha-0.754-0.804)
- Авлигын талаарх жендэрийн ямар хэв шинжүүд байна вэ? (Жендэр авлигатай тэмцэхэд чухал хувь нэмэр оруулах үү?)
- Жендэр ба авлига холбоо хамааралтай юу? (Жендэрийн онцлогийг харуулсан 7 үзүүлэлт Cronbach alpha-0.915)

Хэмжих үзүүлэлтийн хувьд 0.700-аас өндөр байгаа тохиолдолд статистикийн хувьд найдвартай гэж үздэг бөгөөд хэмжих үзүүлэлтүүд найдвартай үр дүн үзүүлсэн тул дараагийн шинжилгээг хийх боломжтой гэж судалгааны баг үзсэн болно.

Мэдээллийн боловсруулалт. Энэхүү судалгааны хүрээнд цугларсан чанарын мэдээлэлдээ нас, хүйсийн онцлог байдал, хот, орон нутгийн ялгаа зэргийг сэдэв тус бүрээр нь харьцуулж, гүнзгийрүүлсэн шинжилгээг хийв. Ярилцлагууд монгол хэл дээр шивэгдсэн бөгөөд тухайн ярилцлагын тэмдэглэлтэй нэг бүрчлэн танилцаж, утгын шинж тэмдэг бүрээр нь кодлов. Харин тоон мэдээллийг SPSS 27.0 программ дээр боловсруулав.

3.6 Судалгааны хязгаарлагдмал талууд

Авлига ба жендэрийн холбоо хамаарлын судалгаа нь ажлын даалгаварт тусгасан зорилт, мэдээлэл цуглуулах аргууд болон судалгааны багт өгөгдсөн цаг хугацаа, нөөц зэргээс хамааран тодорхой хүрээнд хязгаарлагдсан болно. Тухайн судалгааны судлах зүйл, аргыг судалгааны эхлэл шатанд захиалагч талтай хийсэн уулзалт болон 2024 оны 03 сарын 10-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний алба болон ОУЭЗХ-ын Хөтөлбөрийн менежертэй хийсэн уулзалтаар танилцуулж, холбогдох саналуудыг авч, судалгааны хүрээ, арга зүй болон хэрэглэгдэхүүнд тусгаж, 2024 оны 04 сард захиалагчаас албан ёсоор зөвшөөрөл авч эцэслэсэн болно.

Судалгааны дизайн ба тоон шинжилгээний хүрээ. Судалгааны дизайн тоон болон чанарын судалгааны арга зүйд суурилсан ба голлох арга нь тоон судалгааны арга байсан тул аливаа үзэгдэл, үйл явцыг тодорхойлох байдлаар тайлан бичигдсэн болно. Тоон судалгааны түүврийн хэмжээ нь үндэсний хэмжээний төлөөллийг хангахгүй бөгөөд нийслэл хотын дүүргүүд болон бүсийн төлөөлөл болох аймгуудаас судалгаанд хамрагдсан иргэдийн нөхцөл байдлыг илэрхийлнэ. Авлига ба жендэр сэдвээр анх удаа хийсэн судалгаа тул үр дүнг бусад судалгааны үр дүнтэй харьцуулах, зүй тогтлыг шинжлэх боломжгүй.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын арга. Баримт бичгийн шинжилгээгээр авлига ба жендэрийн холбоо хамаарлын судалгааг бусад улс орнуудад хийсэн чэх тайлангуудтай танилцах боломж хомс тул цөөн тооны тайлан, эх сурвалжийг судалгаанд ашигласан.

Судалгааны хүрээнд баримт бичигт тоон дүн шинжилгээ хийж, авлига, ашиг сонирхлын талаар гаргасан өргөдөл гомдлын өнөөгийн нөхцөл байдлыг хүйсээр ялгасан баримт, нотолгоонд тулгуурлан гаргахаар төлөвлөсөн байсан боловч дээрх байдлаар ялгасан баримт мэдээ холбогдох байгууллагаас олдсонгүй.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгтэй холбоотой иргэдийн хүн ам зүйн мэдээлэл нь дутуу байгаатай холбоотой бүрэн дүүрэн шинжилгээг хийж чадаагүй. Хэргийн материал нь гол төлөв жижиг авлигатай холбоотой, харин өндөр түвшний авлигын мэдээлэл ил тод биш, хаалттай байршуулсан нь харьцуулан дүн шинжилгээ хийх боломжгүйд хүргэсэн.

Ганцаарчилсан ярилцлагын хувьд асуултуудын хариулт нь жигд биш байж болно. Өөрөөр хэлбэл, тухайн хүн хариулахаас татгалзсан, зарим тохиолдолд мэдээлэл өгөх боломжгүй байх, хариулж мэдэхгүй байх зэрэг олон шалтгаанаар асуулт бүрд цугласан хариултын тоо ялгаатай байна.

3.7 Судалгааны үр дүнг тархаасан байдал

Судалгааны тайланг захиалагч талд хүлээлгэн өгсний дараа холбогдох байгууллагуудын дунд судалгааны үр дүн, санал зөвлөмжийн талаарх хэлэлцүүлгийг 2024 оны 05 сарын 15 болон 30-нд хоёр удаа зохион байгуулсан. Судалгааны эхний болон удаах үр дүнгээр захиалагч тал болон Авлигатай тэмцэх газрын судалгаа шинжилгээний албаны дарга, комиссаруудад танилцуулга хийж, санал авсан болно.

3.8 Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл

А. Тоон судалгаанд оролцогчийн мэдээлэл

Монгол Улс дахь авлига ба жендэрийн холбоо хамаарлыг тодорхойлон гаргахдаа иргэдээс асуулгын аргыг ашиглан мэдээлэл цуглуулсан болно. Санал асуулгын судалгаанд нийт 1548 иргэн оролцсоноос 748 иргэн буюу 49.5% нь Улаанбаатар хотын 9 дүүргээс, 50.5% буюу 800 иргэн бүсээс сонгогдсон дөрвөн аймгаас түс түс хамрагдсан байна. Мөн судалгаанд оролцогчдын 654 буюу 41.3% нь эрэгтэй, 930 буюу 58.7% нь эмэгтэй хүмүүс байна. Судалгаанд оролцогчдын насны байдлыг авч үзэхэд дунджаар 39 настай, хамгийн залуу нь 18, өндөр нь 76 настай оролцогчид байна.

Хүснэгт 3. Санал асуулгад оролцсон иргэдийн мэдээлэл (хүйс, байршил, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар)

			Хүйсийн байдал		Нийт
			Эрэгтэй	Эмэгтэй	
Аймаг, нийслэл	Улаанбаатар	тоо	343	441	784
		хувь	43.8	56.3	100.0
	Орхон	тоо	67	133	200
		хувь	33.5	66.5	100.0
	Өмнөговь	тоо	81	119	200
		хувь	40.5	59.5	100.0
	Ховд	тоо	92	108	200
		хувь	46.0	54.0	100.0
	Дорнод	тоо	71	129	200
		хувь	35.5	64.5	100.0
	Боловсролгүй	тоо	4	6	10
		хувь	40.0	60.0	100.0
Боловсролын түвшин	Бага	тоо	8	8	16
		хувь	50.0	50.0	100.0
	Суурь	тоо	49	40	89
		хувь	55.1	44.9	100.0
	Бүрэн дунд	тоо	159	178	337
		хувь	47.2	52.8	100.0
	Техник мэргэжлийн	тоо	83	63	146
		хувь	56.8	43.2	100.0
	Дээд	тоо	351	635	986
		хувь	35.6	64.4	100.0
Хөдөлмөр эрхлэлт	Байнгын ажилтай	тоо	383	620	1003
		хувь	38.2	61.8	100.0
	Улирлын шинж чанартай ажилтай	тоо	59	42	101
		хувь	58.4	41.6	100.0
	Түр зуурын ажилтай	тоо	17	20	37
		хувь	45.9	54.1	100.0
	Малчин	тоо	16	28	44
		хувь	36.4	63.6	100.0
	Ажилгүй	тоо	24	31	55
		хувь	43.6	56.4	100.0
	Тэтгэмж, групп/ХБИ/	тоо	37	33	70
		хувь	52.9	47.1	100.0

Оюутан, сурагч	тоо	63	76	139
	хувь	45.3	54.7	100.0
Бусад	тоо	55	80	135
	хувь	40.7	59.3	100.0
НИЙТ	тоо	654	930	1584
	хувь	41.3	58.7	100.0

Судалгааны үр дүнгийн мэдээллийг хүйсээр болон байршлаар харьцуулж, жөндөрээс үүдэлтэй авлигын онцлог ялгааг тодорхойлсон болно.

Б. Чанарын судалгаанд оролцогчийн мэдээлэл

Авлига ба жөндөрийн холбоо хамаарал, учир шалтгааныг тайлбарлахдаа судалгааны мэдээлэл цуглуулах хагас бүтэцлэгдсэн сурвалжилгын аргыг ашигласан болно. Сурвалжилга нь авлигын талаарх ерөнхий ойлголт, төсөөллийг гаргахаас гадна тухайн үзэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлс, шалтгаан, мөн чанарын тайлбарыг бидэнд олгож буйгаараа тоон судалгааны үр дүнгээс давуу талтай юм. Ганцаарчилсан ярилцлагад 8 эмэгтэй, 8 эрэгтэй хамрагдсанаас насны бүтцийн хувьд хамгийн бага нь 36 настай, хамгийн ахмад нь 56 настай, дунджаар 18 жил ажилласан туршлагатай мэргэжилтэн, эрх бүхий албан тушаалтнуудыг судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдсан 16 оролцогчийн 4 нь бизнесийн салбарын, 3 нь банк, санхүүгийн салбарын, 2 нь шүүх, хууль тогтоох байгууллагын, 2 нь боловсролын салбарын болон бусад төрийн байгууллагын төлөөлөл байв.

Хүснэгт 4. Ганцаарчилсан ярилцлагад оролцсон эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл

№	Салбар	Байгууллага	Хүйс	Нас	Ажилласан жил	Албан тушаал
1	Бизнес	Мон-Энко ХХК	Эмэгтэй	37	17	Шуурхай удирдлагын тасгийн дарга
2	Банк, санхүүгийн салбар	ХААН Банк	Эмэгтэй	43	13	Менежер
3	Шүүх, хууль тогтоох байгууллага	Ховд аймгийн Цагдаагийн газар	Эмэгтэй	36	13	Зээлийн багц хариуцсан менежер
4	Банк, санхүүгийн салбар	Хас банк	Эрэгтэй	45	21	Салбарын захирал
5	Боловсролын салбар	Орхон аймгийн ЕБС	Эмэгтэй	42	19	Захирал
6	Эрүүл мэндийн салбар	Орхон Аймгийн Эрүүл мэндийн газар	Эмэгтэй	53	27	Ахлах мэргэжилтэн
7	Бизнес	Глобал бриж констракшн	Эрэгтэй	51	26	Гүйцэтгэх захирал

8	Банк, санхүүгийн салбар	Нийслэлийн прокурорын газар	Эрэгтэй	49	18	Прокурор
10	Шүүх, хууль тогтоох байгууллага	Өмнөговь аймгийн Хууль эрх зүйн хэлтэс	Эмэгтэй	40	13	Ахлах мэргэжилтэн
11	Боловсролын салбар	Өмнөговь аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар	Эрэгтэй	56	28	Ахлах мэргэжилтэн
12	Соёл, урлаг	Өмнөговь аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар	Эмэгтэй	45	19	Ахлах мэргэжилтэн
13	Хөдөлмөр, халамж	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	Эрэгтэй	46	13	Ахлах мэргэжилтэн
14	Татвар	Дорнод аймгийн Татварын хэлтэс	Эмэгтэй	41	16	Ахлах мэргэжилтэн
15	Бизнес	Хувиараа бизнес эрхлэгч	Эрэгтэй	46	22	
16	Бизнес	Барилгын компани	Эрэгтэй	47	19	Захирал

Шүүхээр шийдвэрлэсэн авлигын хэрэгт хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан жендэрийн ялгаатай байдал авлига, авлигын талаарх туршлагад хэрхэн нөлөөлж буйг тайлбарласан болно. Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим системээс (<https://www.shuukh.mn/#gsc.tab=0>) сүүлийн 3 жилийн нийт 28 материалтай танилцан шинжилгээ хийсэн. Баримт бичгийн шинжилгээнээс үзэхэд Аймгийн эрүүгийн анхан шатны шүүх болон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр нийт 11 хэргийг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хүснэгт 5. Шүүхээр шийдвэрлэгдсэн авлигын гэмт хэрэг, газар зүйн байршлаар

	Аймаг/дүүрэг	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Аймгийн эрүүгийн анхан шатны шүүх	Аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
1	Орон нутаг	Дархан-Уул аймаг	-	1
2		Сүхбаатар аймаг	-	2
3		Увс аймаг	-	1
4		Сэлэнгэ аймаг	-	1
5		Булган аймаг	-	1
6		Завхан аймаг	-	1
7		Дорноговь аймаг	1	-
8		Орхон аймаг	1	-
9		Ховд аймаг	1	-
10	Улаанбаатар хот	Сонгинохайрхан дүүрэг	7	-
11		Сүхбаатар дүүрэг	4	-
12		Баянзүрх дүүрэг	1	-
13		Баянгол дүүрэг	3	-
14		Хан-Уул дүүрэг	1	-
15		Чингэлтэй дүүрэг	1	-
	НИЙТ	17	6	5

Шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдээс 10 гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4.4 буюу “Нийтийн албан тушаалтан хахууль авах” гэсэн зүйл заалтаар шийдвэрлэгдсэн байна. Нийт 24 хэргийг гэм бүрүүтайд тооцон ял оногдуулсан. Авлигын гэмт хэрэгт гол төлөв торгох, эрх хасах ялыг түлхүү оноож байгаа нь анхаарал татаж байна.

ДӨРӨВ. АВЛИГА БА ЖЕНДЭРИЙН ХОЛБОО ХАМААРЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1 Авлига ба жендэрийн суурь нөхцөл байдал

Авлигын суурь нөхцөл байдал. Авлига, ашиг сонирхлын зөрчил нь дэлхий нийтийн өмнө тулгарсан нийгмийн томоохон асуудал юм. Авлига нь төрийн эрх мэдэл, нөөц бололцоог өөртөө, хувийн ашиг орлого олохын тулд урвуулан ашиглах үзэгдэл бөгөөд урвуулан ашиглах гэдгийн гол учир нь шан харамж авсныхаа хариуд албан тушаалтан нь төрийн эрх ашиг, сонирхлын эсрэг чиглэсэн үйлдэл хийдгээрээ онц аюултай гэж үздэг байна. Авлигыг иргэд олон янзаар тодорхойлж байгаа хэдий ч төрийн албан тушаалын эрх мэдлээр бизнес хийх гэсэн тодорхойлолт давамгайлж байна⁶.

Монгол Улсын түүхийн тодорхой үе шатуудад авлигын төрөл, түүний шинжүүд, төр, нийгэм, соёлын харилцаанд хэвшин тогтож уламжлагдан ирсэн нь нийгмийн тодорхой харилцаанд одоо ч илэрсээр байна. Түүхээс харахад Монгол Улсад авлига нь төрийн харилцаанд ёс заншил болон тогтож иржээ. Энэ үед монголчууд баяр ёслол, албан тушаал, зэрэг дэв авах эсвэл бусад ажлаа бүтээхийн тулд ямар нэг байдлаар гар цайлгах мөнгө, эд зүйл өгдөг байсан ч авлига гэж тооцож байгаагүй юм. Хүмүүс хоол, хүнс түүнчлэн жижигхэн зүйлээс эхлээд их хэмжээний үнэ бүхий бэлэг, мөнгө, эд зүйлсийг хахуульд өгч авалцан шашны цол, хэргэм, төрийн албан тушаал, эрх мэдэл байр суурийг мөнгөөр худалддаг байсан нь ердийн үзэгдэл байжээ.


1990-ээд он хүртэлх хугацаанд төрийн ил тод байдал байхгүй байсан учраас авлигын тухай асуудал олон нийтийн дүнд хэлэлцэгдэхгүй, зөвхөн тодорхой хүрээнд нууцлагдмал байсан. Энэ үед монголчууд хувийн өмч хөрөнгөгүй, эд хөрөнгийн эрх мэдэл эдэлдэггүй байсан учраас санхүүгийн хувьд ашиг сонирхлын зөрчилдөөнгүй, түүнчлэн нийгмийн хэв журам ба социалист үзэлтнүүдийн ёс суртахууны зарчим, үнэ цэн, нэг намын ноёрхлыг оршин тогтнохыг зөвшөөрдөг нь энэ төрлийн гэмт хэрэг гарах нөхцөл бүрддэггүй байсан байна. Түүнчлэн улс төрд авлигын тухай ойлголт ил гарч байсангүй. Үнэндээ төрийн дээд давхаргад хувийн ашиг сонирхлын төлөө нийгэм дэх байр суурь ба эрх мэдлийг хэтрүүлэх зэргээр авлига нь хязгаарлагдмал хүрээнд тархаж байсан бөгөөд хэвлэн нийтлэх эрх чөлөөгүй байсан учраас нийгэм, иргэдийн дүнд авлигын тухай ойлголт түүний талаарх мэдээлэлгүй байснаас энэ талаар мэдэж чаддаггүй байжээ.

Монгол Улс дахь авлига нь улс төр, зах зээлийн эдийн засгийн өөрчлөлт, ардчилсан чөлөөт үзэл, хувийн хэвшил бий болж эдгээрээс үүдэн гарсан нийгмийн харилцааны өөрчлөлт болон түүхийн тодорхой үе шатуудад авлигын төрөл, түүний шинжүүд, төр, нийгэм, соёлын харилцаанд хэвшин тогтож уламжлагдан ирсэн нь нийгмийн тодорхой харилцаанд одоо ч илэрсээр байна. Монгол Улс нь 2005 онд Нэгдсэн үндэсний авлигын эсрэг конвенцод нэгдэж, 2006 онд Авлигын эсрэг хууль баталж, 2007 онд Авлигатай

6. Авлигатай тэмцэх газар, (2008) Авлигын ерөнхий төлөв байдлын судалгааны дүн (хураангуй), Улаанбаатар. <https://www.uih.mn/sudalgaa/s/226>

тэмцэх газрыг байгуулан авлигын эсрэг арга хэмжээ авч эхлэн, авлигын эсрэг хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн юм. Гэсэн хэдий ч тодорхой үр дүнд хүрч чадалгүй авлига нь нийгмийн томоохон асуудал хэвээр байгааг 2023 оны Авлигын төсөөллийн индексээс (АТИ) харж болно.

Дүрс 3. Авлигын төсөөллийн индекс, 2023 он



Эх сурвалж: <https://www.transparency.org/en/cpi/2023>

Статистикийн тоо баримтаас үзэхэд Монгол Улсад 2020 онд 314, харин 2022 онд 475 авлигын гэмт хэрэг бүртгэгдсэн⁷ нь энэ төрлийн гэмт хэргийн цар хүрээ нэмэгдэж байгааг илтгэнэ.

2023 онд явуулсан АТГ-ын Шударга байдлын үнэлгээний судалгаагаар гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ), дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ), бодлогод оролцогчийн үнэлгээ (БОҮ) 1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг шударга байдлын үнэлгээний 0-100 хүртэлх хэмжээст шилжүүлэн гаргасан байна. Судалгаанд оролцогчдоос Монгол Улсын авлигын шалтгааныг тодруулахад 17.8 хувь нь албан тушаал, эрх мэдлээ үрвүүлэн ашигладаг, 16.1 хувь нь цалин, орлого бага, 13.6 хувь нь авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийн хангалтгүй байдал, 8.9 хувь нь төрийн үйлчилгээ удаан, цаг хугацаа их шаарддаг, 8.3 хувь нь ажлаа хурдан бүтээх гэсэн хандлагаас шалтгаалж байна гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдоос яагаад эдгээр шалтгаануудыг нэрлэж байгаа талаар тодруулахад төрийн албан хаагчдын цалин бага учраас тэд авахыг хүсдэг байх, нөгөө талаар иргэд яагаад өгөх сонирхолтой байдаг талаар тодруулахад төрийн үйлчилгээ удаан, цаг хугацаа их зарцуулдаг, төрийн албан хаагчид ёс зүйгүй байдаг, их зан гаргадаг, хүнд суртал их байдаг учраас ажлаа аль болох

7. YCX (2023) Монгол Улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар, <https://www.1212.mn/mn/statistic/file-library/view/65217112>

хурдан бүтээх гэж өгдөг талаар, мөн эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, ядуурал, үнийн өсөлт, улс төр, нийгмийн өнөөгийн тогтолцоо буруу байгаа нь нөлөөлж байгаа талаар мөн дурдаж байв⁸. Судлаачид авлигын шалтгааныг нь төрийн албан хаагчийн цалин хангамж бага, төрийн албан хаагчдад эрх мэдлийг хавтгайруулан олгосон, нийгмийн бүх харилцаанд ялангуяа эдийн засагт төрийн оролцоо ихээс гадна тэр нь хүнд суртлын шат дамжлагад хүлээтэй байх явдал зэрэг бөгөөд төрийн албан хаагчдын ёс зүйг зөв хэвшүүлэн мөрдүүлэх ажил хийгдэхгүй байгаа нь асуудал болдог гэж үздэг.

Авлига гарч буй салбараас нь хамааруулан улс төр, захиргаа, бизнесийн салбар дахь авлига гэх мэтээр ангилдаг. Улс төрийн авлига нь ихэвчлэн сонгуулийн үйл явцтай холбоотойгоор илэрдэг бол захиргааны авлига нь бодлогын хэрэгжилтийг гажуудуулах үйлдлээр илэрдэг.

Бизнесийн салбар дахь авлига. Бизнесийн орчин дахь авлигын шалтгаан, нөхцөл судалгааг 2013 онд гүйцэтгэсэн ба авлигад өртдөг салбаруудын нэгээр уул уурхайн салбарыг нэрлэсэн. Уул уурхай салбарын авлигад өртөх 5 үндсэн шалтгааныг тодорхойлсон. Үүнд: улс төрийн тогтворгүй байдал, хууль эрх зүйн орчин боловсронгуй болоогүй, хайгуулын болон ашиглалтын зөвшөөрөлтэй холбоотой, орон нутагт төрийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд, НӨАТ бүрдүүлэлт шаарддаг зэрэг юм. Тодруулбал, гүнзгийрүүлсэн ярилцлагуудын үр дүнгээр улс төрийнхний хувьд намаа бэхжүүлэх, өөрийгөө мөнгөжүүлэх томоохон сонирхол хамгийн түрүүнд энэ салбарт тусгалаа олдог байна⁹. Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгаа нь 2018 онд хийгдсэн ба судалгааны үр дүнд бизнесийн орчин, нөхцөл нь өмнөх онуудтай харьцуулахад дордсон гэж бизнес эрхлэгчид үзэж байна. Мөн бизнес эрхлэгчид Татварын алба, Мэргэжлийн хяналт болон Гаалийн байгууллагыг авлигад хамгийн ихээр өртсөн байгууллагаар нэрлэсэн бөгөөд бизнес эрхлэхэд хамгийн их саад бэрхшээл учруулж буйг онцолсон байна. 2016 оныхтой харьцуулахад төрийн байгууллагын авлигын нөхцөл байдал бага зэрэг сайжирсан үзүүлэлттэй байгаа хэдий ч хувийн хэвшил дэх авлигын түвшинтэй харьцуулахад муу үзүүлэлттэй ба “Төрийн үйлчилгээ” нь авлигад хамгийн ихээр өртөмтгий салбарт тооцогдсон хэвээр байгаа юм. Судалгаанд оролцогчдын ихэнх нь төрийн албаны авлига тэдгээрийн бизнест “маш ихээр” буюу “тодорхой хэмжээнд” нөлөөлсөн гэж мэдэгдсэн байна. Авлигыг зогсоох чиглэлд Засгийн газраас гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаа болон хууль эрх зүйн тогтолцоонд итгэх бизнес эрхлэгчдийн итгэл сул байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна¹⁰. Харин 2019 онд хийгдсэн **Бизнесийн орчин дахь авлигын шалтгаан нөхцөл** судалгааны үр дүнгээс үзэхэд төрийн албан хаагчид ч, аж ахуйн нэгжүүд ч авлига авч, өгч байгаа нь ашиг сонирхол нь таарч, аль тал нь нөгөөгөөсөө хамаарах байдлыг бий болгодог. Нэг талаас бизнес тодорхойгүй, тогтворгүй бодлого, төрийн албан хаагчдын хүнд суртлаас болж авлига өгөхөөс өөр аргагүйд хүрдэг, нөгөө талаас бизнес эрхлэгчид өрсөлдөх давуу тал, ашиг

8. АТГ, (2023, 12 11). Авлигатай тэмцэх газар. <https://iaac.mn/uploads/users/1279/files/V%20boti.pdf>

9. Д.Оюунцэцэг, Г.Түмэннаст, М.Батбаатар ба бусад. (2019). Бизнесийн орчин дахь авлигын шалтгаан, нөхцөл. Социологи, №12 (500), 144-161.

10. Азийн сан, (2018) Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал, Улаанбаатар. <https://asiafoundation.org/publication/бизнес-эрхлэлтийн-орчин-дахь-авлигын/>

орлогоо нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, хууль ёсны татвараас зайлсхийхийн тулд төрийн албан хаагчдад авлига санал болгодог. Хувийн хэвшил нь цаг хугацаа, хөрөнгө оруулалт, зээл зэрэг хүчин зүйлээс ихээхэн хамааралтай ба барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ихэнх компаниуд төрийн худалдан авалтаас ихээхэн хамааралтай байдаг нь авлигад нөлөөлж буй хүчин зүйл юм¹¹. Бизнесийн салбарын барилгын худалдаа, үйлчилгээ эрхлэлт дэх авлигын судалгааны үр дүнгээр гол төлөв гааль, тусгай зөвшөөрөл авах, татвар, тендерийн үйл явцад авлига өгдөг гэжээ¹².

Шүүх, хяналтын байгууллага дахь авлига. Монголын хуульчдын холбооны статистик тоон мэдээллээр 2022 онд 6738 хуульч байгаагийн 3925 нь эмэгтэй буюу 58.2 хувь нь эмэгтэй байна. Шүүгчээр нийт 502 хүн ажиллаж байгаагийн 315 буюу 62.7 хувь нь эмэгтэй, улсын хэмжээнд 592 прокурор байгаагийн 306 буюу 51.6 хувь нь эмэгтэй тус тус байв¹³. 2017 онд 3103 эмэгтэй байсан ба 2023 онтой харьцуулахад 26 хувиар өссөн дүнтэй байгаа нь хуулийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэн төлөв ажиглагдаж байна. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа¹⁴-гаар авлигын цар хүрээ, авлигын хэлбэрийн индекс, авлигын шалтгаан, нөхцөлийн индекс, авлигын хор үршиг, дагаврын индекс гэсэн 4 шалгуур үзүүлэлтээр хэмжсэн. Судалгааны үр дүнгээр шүүх, прокурор, цагдаагийн байгууллагад авлигын тархалт их байна гэж үнэлсэн. Авлига өссөн үйл ажиллагааны төрөлд прокурорын хяналт, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа бусад үйл ажиллагаатай харьцуулбал илүү авлигад өртдөг байна. Ажил, албан тушаалд томилох, оруулах, үнэтэй бэлэг өгөх, ашиг орлогоо хуваалцах, шагнал цол тэмдгээр шагнах, бэлэн мөнгө өгөх гэсэн 5 авлигын хэлбэр түгээмэл байна.

Монгол Улсын Шүүхийн индекс судалгааг 2021 онд хийсэн ба олон нийтийн санал асуулга, салбарын шинжээчдийн буюу мэргэжилтнүүдийн санал асуулга, захиргааны мэдээлэл гэсэн үндсэн 3 эх сурвалжийн хүрээнд цуглуулсан мэдээллийг тоон илэрхийлэлд хувирган үнэлсэн. Энэхүү нэгдсэн оноо нь шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал, шүүхийн нээлттэй, ил тод байдал, шүүхэд итгэх олон нийтийн итгэл, шүүхийн дэд бүтэц, нөөц, шүүгчийн ёс зүй ба хариуцлага, шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа гэсэн 6 үндсэн хэмжигдэхүүн, түүнээс улбаалсан 42 дэд хэмжигдэхүүн, тэдгээрийг илэрхийлэх 108 шалгуур үзүүлэлтэд үндэслэсэн байна¹⁵. Судалгааны үр дүнгээр манай улсын шүүх нийт 51.94 оноог авсан ба 42 хэмжигдэхүүнээс шүүгчийн сахилгын зөрчлийн гомдол, түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээллийн ил тод байдал хамгийн бага оноог буюу 30 оноо, харин хэрэг шийдвэрлэлтийн хувь хамгийн өндөр буюу 89.92 оноог авсан байна. Түүнчлэн Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс хийгдсэн тандалт судалгаагаар иргэдийн шүүхэд итгэх итгэл буурахад шүүгчийг шударга бусаар хэргийг шийдвэрлэсэн гэсэн

11. МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхим, (2019) Бизнесийн орчин дахь авлигын шалтгаан нөхцөл, Улаанбаатар.

12. Давааням О. (2024) Жижиг дунд бизнес эрхлэлт дэх авлигын асуудалд хийсэн социологийн дүн шинжилгээ (барилгын материал худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн жишээн дээр): Бакалаврын дипломын ажил

13. Монголын хуульчдын холбоо, (2023) Шүүх, хууль тогтоох байгууллагын хүний нөөцийн мэдээлэл, Улаанбаатар.

14. АТГ, (2023) Судалгааны тайлан эмхтгэл V боть: Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа, Улаанбаатар.

15. Нээлттэй Нийгэм Фрум Оюуны Инноваци ТББ, (2021) Монгол Улсын Шүүхийн Индекс 2021. Улаанбаатар. <https://forum.mn/product/237338>

хардлага болон шүүгчийн харилцаа хандлага нөлөөлдөг болохыг баталсан байна¹⁶. Дээрх судалгаануудад хүйсээр ангилж, дүн шинжилгээ хийгдээгүй байгаа нь асуудлын учир шалтгааныг тайлбарлахад учир дутагдалтай байна.

Боловсролын салбар дахь авлига. Боловсролын салбарын авлига шинэ үзэгдэл биш. Тухайлбал, Бразилд багш ажилд авах, Филиппинд сурах бичиг үйлдвэрлэхэд, Монголд СӨБ-д хүүхдийг хамруулахад авлигын зөрчлүүд гарч байсан. 2014 онд ЮНЕСКО-гийн Боловсролын Төлөвлөлтийн хүрээлэнгээс гаргасан судалгаанд боловсролын салбар авлигад өртөж болох боломжуудыг тодорхойлсон. Энд авлигыг залилан, хахууль, луйвар, шахалт, тал тохой татах гэсэн 5 үндсэн төрөлд хувааж авч үзсэн¹⁷. Залилан бол эрх мэдэлтнүүд боловсролын салбарт зориулсан төсвийн хөрөнгийг улс төрийн сурталчилгаанд ашиглах, сургуулийн эд хөрөнгийг хувийн сонирхлоор авч хэрэглэх замаар илэрдэг байна. Элсэлтийн оноо хүрээгүй боловч сургуульд элсэх, мэдлэг чадвар дутмаг боловч ажилд орох, аливаа ажил төрлөө бүтээхийн тулд авлига өгөх явдал боловсролын салбарт их гардаг. Боловсролын салбарт хуурамч диплом, гэрчилгээ үйлдэх, худалдаж авах, курс, дипломын ажил, диссертацийг үйлдвэрлэдэг үйлчилгээ хууль бусаар явуулах, интернэтээр гэрийн даалгавар, шалгалтын материал тараах зэргээр луйврын үзэгдэл илэрдэг. Айлган сүрдүүлж, шахалт үзүүлж хөрөнгө мөнгө татах явдал боловсролын салбарт авлигын бусад хэлбэрээс ховор тохиолддог хэдий ч оюутан сурагчдад бэлгийн дарамт үзүүлэх, эцэг эхчүүдээс элдэв шалтгаанаар мөнгө татах, хэрэгцээгүй ном, хэвлэл, бараа материал шахах зэрэг нь элбэг тохиолддог байна.

Эрүүл мэндийн салбар дахь авлига. Эрүүл мэндийн салбар дахь албан бус төлбөрийг олон нийт, иргэд гар цайлгалт гэж үзэх хандлага хамгийн их жин дарж байгаа бол эмч, эмнэлгийн ажилтан 50 гаруй хувь нь буюу 2 хүн тутмын нэг нь баярласан сэтгэлээс үүдэлтэй зүйл гэж үзсэн. Гар цайлгалт нь гол төлөв бэлэн мөнгө өгөх, хоол, цөөн тохиолдолд бэлэг дурсгал хэлбэрээр үйлдэгддэг байна. Түүнчлэн авлигын нэг хэлбэр болох албан түшаалтан ах дүү танил талаа харж үйлчлэх, эсвэл тэдэндээ давуу тал бий болгох явдал түгээмэл байна. Эмчлүүлэгчийн зүгээс эмчид багагүй хэмжээний мөнгө өгөх тохиолдол мэс заслын эмч, шүүх эмч, эмэгтэйчүүдийн эмч нарт ихээхэн тохиолддог¹⁸. Иргэдийн эмч, эрүүл мэндийн ажилтнуудад эмчилгээ, үйлчилгээ авахдаа гар цайлгаж буй гол шалтгаан нь үйлчилгээг аль болох хурдан авах, эмчийг илүү өөртөө анхаарал тавиулах, гар цайлгалт байх ёстой гэсэн хүмүүсийн тогтсон хандлага нь эрүүл мэндийн салбарт албан бус төлбөр түгээн тархах үйл явцад нөлөөлж байна.

Транспэрэнси Интернэшнл Монгол байгууллагаас АТИ-ийн үр дүнтэй холбоотойгоор хэд хэдэн зөвлөмжийг өгсөн¹⁹. Үүнээс жөндөртэй холбоотой дараах асуудлыг онцолж байна. Үүнд:

- Иргэдийн мэдэх эрхийг хангах асуудал доголдсон.
- Шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангаагүй.

16. Шүүхийн Ерөнхий зөвлөл, (2023) Шүүхийн өнөөгийн нөхцөл байдлын тандалт судалгаа. Улаанбаатар. https://www.judcouncil.mn/file/research/2_Шүүхийн%20өнөөгийн%20нөхцөл%20байдлын%20тандалт%20судалгаа.pdf

17. ШУТИС, (2017) Боловсролын систем дэх авлига, Улаанбаатар. https://www.must.edu.mn/media/uploads/files/zowlomj3_Hi0Xo7r.pdf

18. Батбаатар М. ба бусад (2013) Эрүүл мэндийн салбар дахь авлигын шалтгаан, үр дагавар, Улаанбаатар.

19. АТГ, (2024) Авлигын төсөөллийн индексийн 2023 оны үр дүн. Улаанбаатар.

- Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх, төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдрэмж дутмаг.
- Авлигыг үүсгэж буй бас нэгэн шалтгаан бол Төрийн өмчит компаниудын хууль бус хүний нөөцийн томилгоо юм. Хүний нөөцийн томилгоог шударга, нээлттэй, ил тод, мерит зарчимд суурилан явуулах шаардлагатай бөгөөд төрийн өмчит компанийн засаглалыг хангалтгүй гэж дүгнэсэн байна.
- УИХ-аас хууль тогтоомж зөрчин иргэдийн мэдэх эрхэд халдаж, олон нийтийн хэлэлцүүлэггүй, судалгаагүй хууль баталсан нь ардчиллын олон талт байдлын үнэлгээ, хуулийн засаглалын үнэлгээгээр дахин үнэлттай гарсан.

Эндээс үзэхэд авлига буурахгүй байгаа шалтгаан нь шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо хангагдахгүй (эмэгтэйчүүд, ХБИ), төрийн албан хаагчдын хүний эрхийн ойлголт мэдлэг дутмаг, төрийн өмчит компаниудын хүний нөөцийн томилгоо шударга бус, олон нийтийн хэлэлцүүлэгт суурилагагүй хууль баталж байгаа нь жендэрийн тэгш бус байдлыг бий болгоход нөлөөлж байгаа асуудал юм. Түүнчлэн жендэрийн зөрүүтэй байдлын индекс нь авлигын төсөөллийн индекс адил өсөж байгаа нь бие биеэ нөхцөлдүүлж байх талтай.

Жендэрийн нөхцөл байдал. Монгол Улс дахь жендэрийн динамик нь нийгэм-соёлын хэм хэмжээгээр тодорхойлогддог бөгөөд 70 гаруй жил социалист нийгмийг цогцлоон 1990 оны эхэн үед зах зээлийн эдийн засагт шилжсэн. Социалист нийгмийн үед эмэгтэйчүүдийн нөхцөл байдал дээшилсэн. ЗХУ-ын дэмжлэгтэйгээр эмэгтэйчүүдийн боловсролд онцгойлон анхаарсны үр дүнд боловсролтой эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн. Түүнчлэн эмэгтэйчүүдийг хүүхэд харах, асрахад нь төрөөс мөнгөн тэтгэлэг олгох, жирэмсний чөлөө авсан эмэгтэйчүүдийн ажлын байрыг хадгалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, ажиллах хүчний оролцоонд хүйсийн тэнцвэрийг хангах, ижил ажлын байранд ижил цалин олгох зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлсэн²⁰. Монгол Улсын иргэд хүйсээс үл хамааран шийдвэр гаргах түвшинд ялангуяа үндэсний, орон нутгийн хууль тогтоох дээд байгууллагад сонгох, сонгогдох тэгш эрхтэй эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны эрхийг 1924 онд Үндсэн хуулиараа баталгаажуулсан боловч өнөөдөр жендэрт суурилсан хүчирхийллийн асуудал Монголд тулгамдсан асуудал хэвээр байна. Жендэр бол нийгмийн ялгаатай бүлгүүдийн оролцоог хангах, нийгмийн олон талт байдлыг харгалзан тэгш боломжийг бий болгоход чиглэдэг. Жендэр гэдэг нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага юм.

Дэлхийн эдийн засгийн форумаас эдийн засгийн оролцоо ба боломж, боловсролын түвшин, эрүүл мэнд ба эсэн мэнд амьдрах чадвар, улс төрийн эрх мэдэл хоорондын жендэрт суурилсан ялгааны хувьслыг харьцуулан гаргасан.

20. SDC. (2015). Gender analysis in pastoral livestock herding in Mongolia. Retrieved from https://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=&ved=2ahUKEwi67165ureEAxVgk1YBHbmCBBoQFnoECBYQAQ&url=https%3A%2F%2Fwww.eda.admin.ch%2Fdam%2Fcountries%2Fcountries-content%2Fmongolia%2Fen%2FAFS_Gender_Pastoral_2015_Mongolia.pdf&usq=AOvVaw133KEWfenkp1SOM1DJTjd&opi=89978449

Дүрс 4. Жендэрийн зөрүүтэй байдлын индекс



Эх сурвалж: The World Bank, <https://prosperitydata360.worldbank.org/en/indicator/WEF+GGR+INDEX>

Манай улсын Жендэрийн хөгжлийн индекс 2022 онд 0.997 болж, 2015 онтой харьцуулахад 0.046 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна²¹. Түүнчлэн “Улс төрийн эрх мэдэл” үзүүлэлтээр 0.099 оноогоор 113 дугаар байрт орсон нь хамгийн хангалтгүй үзүүлэлттэй байна. Монгол Улс Азийн бүс нутгийн дунджаас 21 хувиас доогуур үзүүлэлттэй байна²².

Хүснэгт 6. Монгол Улсын жендэрийн зөрүүтэй байдлын индекс

Жендэрийн зөрүүтэй байдлын индекс	Байр	Оноо
Эдийн засгийн оролцоо ба боломж	33	0.745
Боловсрол эзэмшилт	67	0.994
Эрүүл мэнд ба эсэн мэнд байдал	1	0.980
Улс төрийн эрх мэдэл	121	0.099

Эх сурвалж: World economic forum, 2023

Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангаж, Тогтвортой хөгжлийн зорилт 2030-ын хүрээнд тавьсан зорилгоо биелүүлэхэд эмэгтэйчүүдийн улс төр дэх төлөөлөл болон ажиллах хүчний оролцооны түвшин хангалтгүй байна. Тухайлбал, ажиллах хүчний оролцооны түвшинд эмэгтэйчүүдийн (51.5 хувь) эзлэх хувь эрэгтэйчүүдээс (66.4 хувь)

21. ЖҮХ, (2024) Монгол Улс: Жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин, Улаанбаатар. <https://www.ncge.gov.mn/book/монгол-улс-жендэрийн-тэгш-байдлын-өнө-2/>

22. The World Bank, (2023) Global Gender Gap Report 2022. <https://www.weforum.org/publications/global-gender-gap-report-2022/in-full/>

14.9 нэгж хувиар доогуур байна. Энэ нь эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх боломжийн хувьд болон цалин хөлс, орлогын хувьд жендэрийн ялгаатай байдлыг харуулж байна²³.

Монгол Улсын нийт сонгогчдын 51 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг бөгөөд тэд сонгуульд идэвхтэй оролцдог. Гэвч УИХ дахь тэдний төлөөлөл нь ердөө 17.1 хувь буюу дэлхийн дунджаас 7.6 хувиар бага байна. Эмэгтэйчүүдийн төлөөлөл, оролцоог улс төрийн шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлснээр нийгмийн олон талт тулгамдсан асуудлыг, ялангуяа авлигыг бүүруулахад хувь нэмэр оруулах боломжтой талаар эрдэмтэн, судлаачид үзэж байна. Олон улсын зөвлөхүүдийн зөвлөмжөөр эмэгтэйчүүд, залуучуудын төлөөлөл авлигатай үр дүнтэй тэмцэж чадна. Учир нь шийдвэр гаргах түвшинд олон талт төлөөлөл байх тусам ил тод нээлттэй байдлыг бий болгодог. Манай улсын хувьд эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл шийдвэр гаргах түвшинд хангалтгүй байна. Авлигын цар хүрээ нэмэгдэхийн хэрээр ядуурал, жендэрийн тэгш бус байдлыг нэмэгдүүлдэг, харин авлига бага байх тусам жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлдэг²⁴. Энэ зууны эхээр хоёр нэр хүндтэй судалгааны багийнхан “Эмэгтэйчүүд илүү шударга хүйс мөн үү?” “Жендэр ба авлига” гэх тайлангаараа парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл ихтэй улс орнуудад авлига доогуур байдгийг нотолсны дараа Дэлхийн банкнаас эхлээд олон байгууллага, судлаачид үүнийг гүнзгийрүүлэн судалсаар байна. Транспаренси Интернэшнл-Монгол ТББ-аас Монгол дахь уул уурхай, авлига ба жендэрийн оролцоо сэдэвт дүн шинжилгээнд²⁵ жендэрийн оролцоо нь төрийн болон хувийн хэвшлийн хүрээний авлигын асуудлыг шийдвэрлэх чухал хөшүүрэг болдог. Уул уурхайн салбар авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигад хамгийн их өртөх эрсдэлтэй байдаг ажээ. Иймд Транспаренси Интернэшнл байгууллагын жендэрийн стратегийн дагуу Транспаренси Интернэшнл-Монгол ТББ нь авлигатай тэмцэх арга хэмжээнд жендэрийн агуулгыг тусгах шаардлагатайг тодорхойлсон.

Хүснэгт 7. Парламентад суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Он	Нийт нэр дэвшигчид	Үүнээс эмэгтэй	Үүнээс эрэгтэй
1992	293	4	289
1996	302	8	294
2000	602	9	593
2004	244	5	239
2008	256	66	190
2012	544	174	370
2016	498	129	369
2020	606	151	455

Эх сурвалж: ЖҮХ

24. Alexander, Amy C. (2021, July 14). Oxford academic. Alexander, Amy C. (2021, July 14). Oxford academic. <https://academic.oup.com/edited-volume/33431/chapter-abstract/290581792?redirectedFrom=fulltext>

25. Transparency International-Mongolia. (2020 оны May). Mining, Corruption and gender inclusivity in Mongolia. <https://transparency.org.au/wp-content/uploads/2020/05/Mongolia-gender-corruption-and-mining.pdf>

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсэгт “томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газарт 15 хувиас, доошгүй байх” гэж зааснаас үзэхэд 18 сайдын 3 нь буюу 14.2 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь хуулийн заалт хэрэгжээгүй, харин 13 дэд сайдын 3 нь эмэгтэй буюу 18.7 хувь байгаа нь хууль заалт хэрэгжсэн байна. Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэгт “төрийн захиргааны удирдах албан тушаалтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл яамдын төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, доошгүй байх гэж заасан. Тоо баримтаас үзэхэд төрийн захиргааны удирдах албан тушаал квот хангагдсан байгааг хүснэгт 7-оос харж болно.

Хүснэгт 8. Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтан ба төрийн захиргааны удирдах албан тушаалтан, 2022-2023 он, хүйсээр

Албан тушаал	2022		2023а		Хуулийн хэрэгжилт
	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	
Сайд	18	3	18	3	Хангагдаагүй
Дэд сайд	14	2	13	3	Хангагдсан
Төрийн нарийн бичгийн дарга	15	1	11	5	Хангагдсан
Агентлагийн дарга	21	3	20	6	Хангагдсан
Яамдын газар, хэлтсийн дарга	154	87	150	160	Хангагдсан
Агентлаг дахь хэлтэс, албаны дарга	207	120	236	102	Хангагдсан

Эх сурвалж: ЖҮХ

Практикт хуулийн зүйл, заалтыг хэрэглэхдээ заасан хувиас хэтрүүлэхгүй гэсэн өрөөсгөл ойлголт байгааг онцлон тэмдэглэж байна. Төрийн захиргааны төв байгууллагын албан тушаалтнуудын хүйсийн харьцааг харахад хуульд заасан квотыг хэрэгжүүлээгүй 3 салбар байна. Эндээс үзэхэд төрийн өндөр дээд албан тушаалд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа нь авлигын гэмт хэрэгт өртөмтгий байхад нөлөөлж байна. Учир нь хүйсийн онцлогийн хувьд эрэгтэйчүүд байгалиас хүч чадалтай, зоригтой, дайчин, эрсдэл хийх чадвартай түүнчлэн ар гэрээ тэжээх ёстой гэсэн жендэрийн хэвшмэл үзэл нь эрэгтэй хүмүүсийг албан тушаалаа үрвүүлэн ашиглан энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх шалтгаан байж болох юм. Энэ талаар тоон болон чанарын судалгааны үр дүнгүүд харуулж байна.

Хүснэгт 9. Төрийн захиргааны төв байгууллагын албан тушаалтан, 2023 он, хүйсээр

Төрийн захиргааны төв байгууллага	Газар хэлтсийн дарга		Квот хангагдсан эсэх
	Эрэгтэй	Эмэгтэй	
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	4	5	Хангагдсан
БШУЯ	7	12	Хангагдсан
Гадаад харилцааны яам	10	6	Хангагдсан
ХНХЯ	8	86	Хангагдсан
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	10	5	Хангагдсан
Сангийн яам	17	8	Хангагдсан
Соёлын яам	7	6	Хангагдсан
Хууль зүй, дотоод хэргийн яам	5	3	Хангагдсан
Эрүүл мэндийн яам	5	10	Хангагдсан.
Барилга, хот байгуулалтын яам	8	4	Хангагдсан.
Эдийн засаг хөгжлийн яам	11	5	Хангагдсан.
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	16	1	Хангагдаагүй
ЦХХХЯ	10	2	Хангагдаагүй
Зам, тээврийн хөгжлийн яам	11	4	Хангагдаагүй
Батлан хамгаалах яам	9	1	Хангагдаагүй
Эрчим хүчний яам	12	2	Хангагдаагүй
НИЙТ	150	160	

Эх сурвалж: ЖҮХ

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх гэж заасан. Тоо баримтаас харахад нийт 16 яамны 7 яам хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй буюу авлигын тархалт ихтэй боловсрол, эрүүл мэнд, хуулийн салбаруудад хүйсийн зөрүүтэй байдал байсаар байна²⁶. Төрийн захиргааны төв байгууллагуудын газар, хэлтсийн дарга нар эмэгтэйчүүд илүү байгаа нь ХНХЯ, БШУЯ болон ЭМЯ голлох нөлөөг үзүүлсэн. Харин авлигад өртөмтгий салбарууд болох уул уурхай, хүнд үйлдвэр, санхүү, барилга хот байгуулалтын хувьд эрэгтэйчүүд зонхилох хандлагатай байна.

26. ЖҮХ, (2024) Жендэрийн салбар зөвлөлийн тайлан. Улаанбаатар.

Хүснэгт 10.Төрийн болон төсөвт байгууллагын нийт ажилтны тоо, 2023 он, судалгааны талбараар

Яам, агентлаг	Нийт төрийн албан хаагчид		Нийт албан хаагч	Аль нэг хүйсийн төлөөллийн доод квотыг хангасан эсэх
	Эрэгтэй	Эмэгтэй		
Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам	47	37	84	Хангагдсан
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	45	61	106	Хангагдсан
Эдийн засаг, Хөгжлийн яам	46	41	87	Хангагдсан
Боловсрол, Шинжлэх ухааны яам	31	75	106	Хангагдаагүй
Эрүүл мэндийн яам	30	73	103	Хангагдаагүй
Хууль зүй, дотоод хэргийн яам	24	54	78	Хангагдаагүй
Батлан хамгаалахын яам	64	17	81	Хангагдаагүй
Сангийн яам	73	79	152	Хангагдсан

Эх сурвалж: ЖҮХ

Аймаг, дүүргийн засаг даргын хувьд нийт 22 засаг даргаас 1 эмэгтэй, засаг даргын орлогчоос 3 эмэгтэй, харин дүүргийн 9 засаг даргаас 1 эмэгтэй, засаг даргын орлогчоос 3 эмэгтэй, 330 сумын засаг даргаас 49 эмэгтэй, 204 хороодын засаг даргаас 88 нь эмэгтэй байгаагаас үзэхэд засаг захиргааны анхдагч нэгжид эмэгтэйчүүдийн манлайлал нэмэгдэж байгаа бол засаг захиргааны нэгж ахих тусам эрэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж байгаа нь харагдлаа²⁷. Нутгийн захиргааны байгууллагын ажиллагчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 11. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын нийт ажилтны тоо, 2023 он, судалгааны талбараар

Нутгийн захиргааны байгууллага	Нийт төрийн албан хаагчид		Нийт албан хаагч	Аль нэг хүйсийн төлөөллийн доод квотыг хангасан эсэх
	Эрэгтэй	Эмэгтэй		
Нийслэлийн ЗДТГ	83	189	272	Хангагдсан
Ховд ЗДТГ	36	51	87	Хангагдсан
Орхон ЗДТГ	23	45	68	Хангагдсан
Өмнөговь ЗДТГ	18	27	45	Хангагдаагүй
Дорнод ЗДТГ	39	51	90	Хангагдаагүй

Эх сурвалж: ЖҮХ

27. ЖҮХ, (2024) Жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны тайлан. Улаанбаатар.

Статистикийн тоо баримтаас харахад нийт 225,205 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас төрийн үйлчилгээний албанд 152,265 буюу 67.6 хувь нь ажилладаг байна. Төрийн үйлчилгээний албанд нийт ажиллагчдын 76.8 эмэгтэй, харин төрийн улс төрийн алба болон төрийн тусгай албанд 23.7~28.2 хувь эмэгтэй байгаа нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй болохыг илтгэнэ. Төрийн үйлчилгээг цаг алдалгүй, чанартай, хүртээмжтэй үзүүлэх үүрэгтэй боловсролын салбарт 104,000 ажиллагчдын 76.6 хувь нь эмэгтэй, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарт 40,400 ажиллагчдаас 81.2 хувь нь эмэгтэй байгаа²⁸ нь эмэгтэй хүйс давамгайлсан салбар хэвээр байгааг баталж байна. Харин Шүүх, хяналтын байгууллагад ажилладаг нийт 6,738 хуульчдын 58.2 хувь эмэгтэй байгаа нь хүйсийн тэнцвэрт байдлыг хангасан салбар гэж үзэж болно.

Эмэгтэйчүүд эрхэлж буй албан тушаалаас хамааран илүү жижиг авлигад өртөмтгий байх төлөв харагдаж байна. Энэ нөхцөл байдлыг олон улсын судалгаанууд ч баталж байна²⁹. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх мэдлийн зөрүүтэй байдал нь эмэгтэйчүүдийг илүү авлигад өртөмтгий болгодог. Авлига нь эрх мэдлийн динамикийг улам хурцатгаж, эмэгтэйчүүдийн нөөцийг ашиглах, мэдээллийг ил тод авах, шийдвэр гаргах эрхийг хязгаарлаж, улмаар нийгэм, соёл, улс төрийн ялгаварлан гадуурхалтыг бэхжүүлж байдаг. Авлигын жендэрийн хэлбэр нь бэлгийн дарамт бөгөөд сексийн дур хүслээ хангах зорилгоор албан тушаалын давуу байдлаа ашиглах асуудал гарсаар байна. Мөн охид, эмэгтэйчүүдийг төрийн үйлчилгээ авсны төлөө мөнгө төлөх бус, бэлгийн харилцаанд орохыг албаддаг асуудал “хөшигний цаана” нуугдмал, бат бөх байсаар байна. Авлига нь охид, эмэгтэйчүүдийн нэр төрийг алдагдуулж, эрүүл мэнд, боловсрол, хөгжих боломжид нь саад учруулж, хүний наймааг дэлгэрүүлэх, бүр цаашлаад амь насанд нь заналхийлдэг нийгмийн тулгамдсан асуудал болохыг онцлон тэмдэглэж байна.

4.2 Жендэрээс үүдэлтэй авлигын ялгаатай ойлголт, төсөөлөл

Авлига хэмээх ойлголтын агуулгыг хэл шинжлэлийн үүднээс авч үзвэл, Монгол хэлний их тайлбар тольд авлига авах гэдгийг ажил үйлээ бүтээхийн тулд бусдаас шан харамж болгон эд юм хууль бусаар авах, авлига өгөх гэдэг нь ажил үйлийг хууль бусаар бүтээхийн тулд эд юм өгөх, авлига хөөх гэдэг нь ашиг олз олохын төлөө зүтгэх гэсэн бол Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь бичигт авлига гэдэг нь ёсон бусаар шунаж авсан эд юм” гэж бичжээ³⁰. Харин Монгол Улсын Авлигын эсрэг хуульд Авлига гэж “албан тушаалын эрх мэдлээ хүвийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг ойлгоно” гэжээ. Энд дүрдсанчлан авлигын талаарх ойлголт, тодорхойлолт нэг талаар ихээхэн субъектив шинжтэй, нөгөө талаас өргөн агуулгатай юм. Судалгааны үр дүнгээс үзэхэд авлигын талаар олон нийтийн дунд харилцан адилгүй, ялгаатай, зарим талаар зөрчилтэй ойлголт, төсөөлөл түгээмэл байна.

28. YCX, (2023) Монгол улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар: <https://www.1212.mn/mn/statistic/file-library/view/65217112>

29. Sarah Brierley, Miguel M. Pereira, Women bureaucrats and petty corruption. Experimental evidence from Ghana, Research and politics, 2023:1-7

30. Цэвэл Я, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар: 2023.

Авлигын эсрэг хуульд³¹ Авлига гэж “албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхгүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг ойлгоно” гэжээ. Энд дүрдсанчлан авлигын талаарх ойлголт, тодорхойлолт нэг талаар ихээхэн субъектив шинжтэй, нөгөө талаас өргөн агуулгатай юм. Судалгааны үр дүнгээс үзэхэд авлигын талаар олон нийтийн дунд харилцан адилгүй, ялгаатай, зарим талаар зөрчилтэй ойлголт, төсөөлөл түгээмэл байна.

Хүснэгт 12. Иргэд, олон нийт авлигыг хэрхэн ойлгож байна вэ?

Тохиолдлууд	Байж болох зүйл		Ёс зүйгүй үйлдэл мөн		Хүнд суртал мөн		Авлига мөн	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
1 Бусдын жишгээр мөнгө, эд зүйл өгөх	17.8	18.6	27.2	29.1	11.9	10.8	43.1	41.5
2 Үйлчилгээ авахын өмнө өөрийн санаачилгаар гарыг нь цайлгах	20.3	20.5	30.7	31.4	11.0	13.2	38.1	34.8
3 Үйлчилгээ авсны дараа талархсанаа илэрхийлэх, хоолонд урих, бэлэг өгөх	31.0	34.4	25.4	24.3	10.4	9.6	33.3	31.7
4 Үйлчилгээг түргэтгэх, хугацаа хожих, оочер дарааллыг алгасахын тулд шан харамж амлах, өгөх	14.1	11.0	29.1	33.0	12.1	11.8	44.8	44.2
5 Ах дүү, танил талаа ашиглаж үйлчлүүлэх, үйлчилгээ авах	18.1	20.5	39.6	42.6	16.4	14.4	26.0	22.5
Дундаж	20.26	21.0	30.4	32.08	12.36	11.96	37.06	34.96

Авлига, түүний төрөл хэлбэр, шинж чанарын тухайд олон улсын хэмжээнд ч нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэг мөр ойлголт хомс юм. Харин жендэр ба авлига сэдэвт энэ удаагийн судалгааны үр дүнгээс үзэхэд эрэгтэй, эмэгтэй хүйсээс хамаарсан онцлог гэмээр ялгаа харагдахгүй байна. Өөрөөр хэлбэл, авлигын цаад мөн чанарын талаарх ойлголт төсөөлөл ижилхэн буюу ойролцоо байгааг харж болно.

Авлига гэдэг юу болох талаар иргэд, олон нийтийн дунд нэгдсэн төсөөлөл байгаа боловч хүйсийн хувьд харьцуулахад ялгаатай бус нэн ойролцоо байгаа нь анхаарал татаж байна.

31. УИХ, (2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр) Авлигын эсрэг хууль, Улаанбаатар: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8928>

Олон нийтийн ойлголт, төсөөллөөр авлига гэж,

- Үйлчилгээг түргэтгэх, хугацаа хожих, оочир дарааллыг алгасахын тулд шан харамж амлах, өгөх явдал гэж эмэгтэйчүүдийн 44.2 хувь, эрэгтэйчүүдийн 44.8 хувь нь тус тус үзсэн.
- Иргэдийн хувьд авлига бол бусдын жишгээр мөнгө, эд зүйл өгөхийг хэлнэ гэж эмэгтэйчүүдийн 41.5 хувь, эрэгтэйчүүдийн 43.1 хувь нь тус тус үзсэн байна.

Ёс зүйгүй үйлдэл гэдгийн доор ах дүү, танил талаа ашиглаж үйлчлүүлэх, үйлчилгээ авахыг түлхүү ойлгож байгаа нь судалгааны нэгэн чухал үр дүн болно. Эрэгтэйчүүдийн 39.6 хувь, эмэгтэйчүүдийн 42.6 хувь нь ах дүү, танил талаа ашиглаж үйлчлүүлэх, үйлчилгээ авахыг ёс зүйгүй үйлдэл болохыг дурдсан.

Хүнд суртал бол үйлчилгээг түргэтгэх, хугацаа хожих, оочир дарааллыг алгасахын тулд шан харамж амлах, өгөхтэй холбоотой гардаг гэж судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн 12.1 хувь, эмэгтэйчүүдийн 11.8 хувь нь үзжээ.

Харин ямар нэг үйлчилгээ авсны дараа талархсанаа илэрхийлэх, хоолонд үрих, бэлэг өгөх нь байж болох зүйл гэж эрэгтэйчүүдийн 31.0 хувь, эмэгтэйчүүдийн 34.4 хувь нь тус тус үзсэн байна. Энэ нь үндсэндээ авлигыг өөгшүүлэх буюу авлигыг хүлцэж буйн илрэл юм.

Энд дурдсан үйлчилгээ авахын өмнөх болон үйлчилгээ авсны дараах ил далд ямар нэг хэлбэрээр төлж буй бүхий л төлбөр нь олон улсын нэршлээр албан бус төлбөр (informal payment or bribe) болно.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн авлигын ойлголт, төсөөллийг хариултын дундаж хувьд тулгуурлан тооцоолж, дараах дүрсэд харуулсан болно.

Дүрс 5. Авлигын талаарх ойлголт, төсөөллийн ялгаа

	(Эрэгтэй-37.06)	Авлига мөн>2.12	(Эмэгтэй-34.94)	
	(Эрэгтэй-12.36)	Хүнд суртал>0.4	(Эмэгтэй-11.96)	
	(Эрэгтэй-30.4)	Ёс зүйгүй үйлдэл<1.68	(Эмэгтэй-32.08)	
	(Эрэгтэй-20.26)	Авлигыг хүлцэх байдал<0.74	(Эмэгтэй-21.0)	

Авлигын шинжтэй дээрх бүхий л үйлдлийн талаарх эмэгтэйчүүдийн ойлголт, төсөөлөл эрэгтэйчүүдээс авлигыг хүлцэх буюу байж болох зүйл гэсэн ойлголт 0.74, ёс зүйгүй үйлдэл гэсэн хувь хэмжээ 1.68 хувиар тус тус өндөр байна. Харин хүнд суртал мөн гэсэн ойлголт, төсөөлөл эрэгтэйчүүдээс 0.4 хувиар, авлига мөн гэсэн ойлголт, төсөөлөл 2.12 хувиар тус тус бага байлаа.

Албан бус төлбөр нь дэлхийн олон улс оронд, ялангуяа постсоциалист орнуудад ихээхэн дэлгэрсэн, ихэнх тохиолдолд хууль бус, төлбөр төлсөн баримтгүйгээр үйлдэгддэг, өгсөн ба авсан нь ярихыг хүсдэггүй нэмэлт төлбөр болно. Авлига чухам аль салбарт илүүтэй үйлдэгдэж байна вэ? гэсэн асуултад иргэд, олон нийтийн хувьд шүүх хууль хяналтын байгууллага болон эрүүл мэндийн салбарт илүү өндөр гардаг гэсэн төсөөлөлтэй байна.


Хүснэгт 13. Таны бодлоор аль салбарт авлига илүү гардаг вэ?/салбарыг үсгийн дарааллаар байрлуулсан/

	Их	Дунд зэрэг	Бага	Байхгүй	Мэдэхгүй
1 Банк санхүү	21.6	39.8	20.1	6.4	12.2
2 Боловсрол	27.1	36.5	24.5	5.5	6.4
3 Бизнес	41.1	27.0	18.8	5.4	7.7
4 Шүүх, хууль хяналтын байгууллага	62.7	19.6	9.0	3.4	5.3
5 Эрүүл мэнд	50.1	28.8	14.3	2.7	4.0
Дундаж хувь	40.52	30.34	17.34	4.68	7.12

Иргэдийн ойлголт, төсөөллийн судалгаанаас үзэхэд шүүх, хууль хяналтын байгууллагад авлига их гардаг гэж 62.7 хувь эрүүл мэндийн салбарт гардаг гэж 50.1% буюу тэн хагас нь үзжээ. Эдгээр хариултад үндэслэн тухайн салбаруудад албан бус төлбөр болон авлига тодорхой хэмжээгээр тархсан болохыг харж болно.

Өмнө дурдсан салбараас ямар нэгэн үйлчилгээг авахдаа хүмүүс эрх бүхий ажилтан, албан тушаалтанд мөнгө, эд зүйлс өгөх явдалтай таарч байсан уу? гэсэн асуултад мэр сэр тохиолддог гэж судалгаанд оролцогчдын 44.3 хувь нь хариулсан байна.

Дүрс 6. Эрх бүхий ажилтан, албан тушаалтанд мөнгө эд зүйлс өгөх тохиолдол



Олон нийтийн төсөөлөлд тулгуурлан авлигыг авч үзэхэд гар цайлгах, албан бус төлбөр төлөх, хахууль өгөх, хүнд суртлыг багасгах, оочир дарааллыг ахиулах гэх мэт ойлголт, хандлага ойролцоо жинтэй, өргөн цараатай тааралдаж байлаа. Бидний судалгаанд олон янз байр суурь бүхий нийгэм, олон нийтийн төлөөлөл оролцсон түл харилцан адилгүй байр суурь илэрхийлсэн байж болох юм.

Юутай ч гар цайлгалт, албан бус төлбөр ойролцоогоор хэдэн төгрөгт багтсан талаар лавлахад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өгсөн мөнгөний дундаж хэмжээ ихээхэн ялгаатай байлаа.


Хүснэгт 14. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гар цайлгалт, албан бус төлбөрийн хэмжээ

	Нийт	Доод	Дээд	Дундаж	Стд. хазайлт
Эрэгтэй	212	20,000.00	15,000,000.00	555,674.53	1,208,865.00
Эмэгтэй	273	10,000.00	7,000,000.00	463,681.3	741,731.05
Нийт	496	10,000.00	15,000,000.00	499,169.35	963,728.63
Хүйсээс хамаарсан зөрүү	10,000.00	8,000,000.00	91,993.23	467,133.9	

Хүснэгтээс үзэхэд эмэгтэй хүмүүс хамгийн багадаа 10 мянган төгрөг, хамгийн ихдээ 7 сая хүртэлх төгрөгийг албан бус төлбөрт төлсөн байхад, эрэгтэйчүүд хамгийн багадаа 20 мянган төгрөгөөс эхлээд хамгийн ихдээ 15.0 сая төгрөг хүртэл төлсөн байна. Дээд болон доод үзүүлэлтийн зөрүүг авч үзэхэд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бараг хоёр дахин илүү төлдөг болохыг судалгааны үр дүн илтгэж байна. Иргэдийн хувьд гар цайлгалт буюу албан бус төлбөрт сүүлийн 12 сарын хугацаанд дунджаар 499.1 мянган төгрөг төлсөн байна. Үүнийг хүйсийн ялгаатай байдлаар авч үзэхэд эрэгтэйчүүд 555.6 мянга, эмэгтэйчүүд 463.6 мянга байгаа бөгөөд зөрүүг тооцож үзэхэд хэмжээний хувьд 100.0 (92.0) орчим мянгаар бага авлига төлдөг ажээ.

Авлига чухам аль салбарт гарч үйлдэгдэж байгаа талаар хүйсийн хувьд ялгаатай байр суурь бий эсэхийг энэхүү судалгааны хариултад үндэслэн тодорхойлсон болно.

График 1. Авлига аль салбарт илүүтэй гардаг талаар хүйсийн ялгаатай байр суурь



Өмнө дурдсан салбараас ямар нэгэн үйлчилгээг авахдаа хүмүүсийн эрх бүхий ажилтан, албан тушаалтанд мөнгө, эд зүйлс өгөх явдалтай таарч байсан уу? гэсэн асуултад хариулсан үр дүнгээс үзэхэд эмэгтэй, эрэгтэйчүүдийн авлигатай таарч байсан тохиолдол ойролцоо, гэхдээ эрэгтэйчүүд бага зэрэг өртөмтгий байгаа нь харагдаж байна.

Тоон асуулгын үр дүнгийн зэрэгцээ чанарын судалгааны хүрээнд иргэдийн дунд хийсэн ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс үзэхэд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ойлголт, төсөөлөл, байр сууриас хамаарч авлигын тохиолдол салбар бүрд харилцан адилгүй тохиолдож байна.

ШИГТГЭЭ 1.

Авлига бол нийгмийн өөрчлөлтөөс үүдэлтэй үзэгдэл гэж хардаг. Банк, санхүүгийн салбар аль болох авлигаас ангид байхыг зорьдог. Хэрвээ зөрчил гаргавал оногдох шийтгэл нь хүнд тул нэг их гараад байдаггүй. Практикаас харахад 1950-1960 оны эмэгтэйчүүд юмыг хахуулиар шийдэхийг эрмэлздэг байсан. Шилжилтийн үед бизнес эрхэлж байх үедээ мөнгө өгөөд шийдээд сүрчихсэн, тогтсон хандлагатай болчихсон.

Банкны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас


Хэрэв өмнө дурдсан салбарт ямар нэг байдлаар тааралдсан бол чухам аль хүйсийн хүнд илүү тохиолдож байсан талаар лавлахад иргэд дараах байдлаар буюу хүйсээс хамаарахгүй аль алинд нь нийтлэг тохиолдож байсан (50.3-57.7) талаар дурджээ.

Хүснэгт 15. Хэрэв дээрх тохиолдолтой таарч байсан бол энэ нь аль салбарт, ямар хүйсийн хүнд тохиолдож байсан бэ?

Байгууллагууд	Зонхилон эрэгтэйчүүд		Зонхилон эмэгтэйчүүд		Аль алинд нь	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1. Банк санхүү	205	16.5	322	26.0	713	57.5
2. Боловсрол	195	15.5	430	34.2	632	50.3
3. Бизнес	294	23.6	315	25.3	636	51.0
4. Шүүх, хууль хяналтын байгууллага	265	20.9	271	21.4	731	57.7
5. Эрүүл мэнд	162	12.5	410	31.5	728	56.0

Энэхүү үр дүнгээс ямар нэг авлигын үйлдэлд хүйс хамаагүй гэсэн дүгнэлтийг хийх нь амархан боловч, үүнийг цааш нарийвчлан харах шаардлагатай болно. Иймд авлига үйлдэгдэж буй салбарын талаарх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байр сууринд дундаж үзүүлэлтийн шинжилгээний аргыг ашиглан үзэхэд дараах онцлог харагдсан юм.

График 2. Авлига аль салбарт илүүтэй гардаг вэ? хүйсийн ялгаатай байр суурь



Таны бодлоор авлига аль салбарт илүүтэй гардаг вэ? гэсэн асуултын хариултыг дундаж үзүүлэлтэд тулгуурлан шинжилгээ хийж үзэхэд, Эмэгтэйчүүдийн бодлоор авлига эрүүл мэндийн салбарт илүү гардаг гэсэн бол, бусад салбарт гардаг гэсэн эрэгтэйчүүдийн байр суурь илүү өндөр байна. Энэ нь эмэгтэй хүмүүс төрөх болон бусад эрүүл мэндийн үйлчилгээг эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас түлхүү авдаг амьдралын туршлагатай холбоотой байж болох юм. Дундаж үзүүлэлтийн шинжилгээнээс үзэхэд шүүх хууль, хяналтын байгууллагад гардаг гэсэн хариулт эрэгтэй (3.34), эмэгтэй (3.29) хүмүүсийн хувьд өндөр байна. Бизнесийн салбарын хувьд эрэгтэйчүүдийн байр суурь өндөр(3.02) байхад эмэгтэйчүүдийн байр суурь арай бага (2.79) байна. Харин боловсролын салбарын авлигын талаар эрэгтэй (2.73), эмэгтэй (2.72) хүмүүсийн байр суурь ойролцоо байв. Сүүлийн жилүүдэд боловсролын салбарын бүртгэл, мэдээллийн сисемийг сайжруулсантай холбоотой авлига буурч байгааг салбарын эрх бүхий албан тушаалтнууд онцолж байв.

ШИГТГЭЭ 2.

Боловсролын салбарт харьцангуй авлигын асуудал байхгүй болсон. Харьяаллын бус хүүхдийг авах ямар ч боломжгүй. Авлигын гол асуудал нь Аймгийн улсын бүртгэлийн хэлтэс дээр байна гэж үзэж байна. ЕБС-ийн Хаврын улиралд харьяаллын хүүхдүүдийн мэдээллээ Улсын бүртгэлийн хэлтсээс авчихдаг. Бүртгэлийн дагуу ажлуудаа төлөвлөөд, хүүхдээ хуваарилдаг ч хичээлийн шинэ жил эхлэх буюу Намар олон хүүхэд нэмэгдээд ороод ирдэг. Үүнээс гадна Төрийн албаны тухай хуульд 2023 онд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотой захирлын сонгон шалгаруулалт шударга явагдах болсон. Үүнээс өмнө хэн нэгний цүнх баригч, эсвэл намын нөлөө бүхий хүний танил тал шууд ЕБС-ийн захирлаар томилогддог байсан.

ЕБС-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Харин банк санхүүгийн авлигын талаар эрэгтэй (2.57) эмэгтэй (2.49) хүмүүсийн байр суурь бусад салбараас харьцангуй доогуур байв.

ШИГТГЭЭ 3.

Банк, санхүүгийн салбарт зээлийн эдийн засагч нар авлигад өртөх эрсдэлтэй байдаг. Банкны хувьд 1 эмэгтэй авлигын хэрэгт холбогдоод хэрэг нь шүүхээр шийдэгдээд явсан тал бий. Сүүлийн жилүүдэд Монгол банкны хяналт сайжирсантай холбоотой 20 саяас дээш төгрөгийн гүйлгээ бүрийг хянадаг болсон.

Банкны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

4.3 Жендэрийн ялгаатай байдал ба авлигын талаарх туршлага

Судалгаанд хамрагдсан иргэд, олон нийт авлигын талаарх туршлагаа хуваалцсан юм. Өөрөөр хэлбэл тухайн салбаруудаас ямар нэг үйлчилгээг авахдаа эрх бүхий ажилтан албан хаагчид мөнгө, эд зүйлс өгөх явдал гардаг гэж судалгаанд оролцогч иргэдийн 53.7% буюу 838 иргэн үгүй гэж хариулсан бол 46.3% буюу 723 иргэн тийм гэж хариулжээ.

График 3. Авлигын талаарх туршлага: тохиолдол



Сүүлийн 12 сарын хугацаанд та эсвэл таны гэр бүлийн хэн нэгэн гишүүн ямар нэгэн ажил амжуулж, төрийн үйлчилгээ авахдаа гар цайлгах, мөнгө өгөх тохиолдол гарсан уу? гэсэн асуултад хариулсан байдлыг хүйсээр харьцуулан авч үзэхэд эрэгтэй хүмүүсийн 49.2 хувь, эмэгтэй хүмүүсийн 44.3 хувь нь тийм гэсэн хариулт буюу ямар нэг байдлаар сүүлийн 12 сарын хугацаанд төрийн үйлчилгээ авахдаа мөнгө өгөх буюу албан бус төлбөр төлөх тохиолдол гарсан байна.

Хүснэгт 16. Чухам ямар албан тушаалтан, эсвэл ажилтанд авлига өгч байсан бэ?

		Хамт цайлж, жижигхэн бэлгээр гар цайлгах		Томоохон эд зүйл бэлэглэх		Нэлээд хэмжээний мөнгө өгөх		Тийм тохиолдол гарч байгаагүй	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	ЕБС-ийн удирдах ажилтан	360	31.8	45	4.0	42	3.7	684	60.5
2	ИДС-ийн удирдах ажилтан	319	27.1	88	7.5	62	5.3	707	60.1
3	Багш	488	38.9	137	10.9	34	2.7	595	47.4

4	Эмнэлгийн удирдах ажилтан	735	54.0	58	4.3	41	3.0	528	33.3
5	Эмч	619	45.1	200	14.6	97	7.1	455	33.2
6	Сувилагч, асрагч	679	49.8	140	10.3	32	2.3	513	37.6
7	Банк, санхүүгийн удирдах ажилтан	271	23.6	91	7.9	69	6.0	718	62.5
8	Банк санхүүгийн гүйцэтгэх ажилтан	170	16.2	52	4.9	42	4.0	788	74.9
9	Шүүх, хууль хяналтын байгууллагын удирдах албан тушаалтан	151	14.4	70	6.7	76	7.3	749	71.6
10	Шүүх, хууль хяналтын байгууллагын гүйцэтгэх ажилтан	166	16.1	67	6.5	48	4.6	752	72.8

Хүснэгтийн мэдээллээс үзэхэд эрүүл мэндийн салбар ихээхэн анхаарал татаж байна. Хамт цайлж жижигхэн бэлгээр гар цайлгах явдал эмнэлгийн удирдах ажилтан (54.0), эмч (45.1), сувилагч асрагчид (49.8) нийтлэг тохиолддог гэж иргэд хариулсан бол томоохон эд зүйл бэлэглэх явдал мөн л эмч (14.6), сувилагч, асрагч (10.3) нийтлэг тохиолддог байна.

Харин Шүүх, хууль хяналтын байгууллагын удирдах албан тушаалтанд (7.3), эмчид (7.1) нэлээд хэмжээний мөнгө өгөх явдал гарсан нь санамсаргүй хэрэг биш бололтой. Авлига өгөх тохиолдол гарч байгаагүй гэсэн хариултыг банк, санхүүгийн гүйцэтгэх (74.9) болон удирдах ажилтан (62.5) илүү өндөр авсан байна.

Эдгээр авлига авсан хэмээн мэдэгдсэн чухам ямар албан тушаалтан, эсвэл ажилтан байсныг цааш мөшгөж, авлигын хэмжээг тооцож үзэхэд авлигын дараах хэмжээг иргэд мэдээлжээ.

Хүснэгт 17. Авлига авч буй албан тушаалтан

Албан тушаалтан	N	Доод	Дээд	Дундаж	Ст.хазайлт
Эмнэлгийн удирдах ажилтан	26	100,000.00	7,000,000.00	774,615.38	1,416,331.12
Эмч	68	50,000.00	15,000,000.00	847,264.71	1,902,523.41
Сувилагч, асрагч	21	100,000.00	3,000,000.00	547,142.86	650,631.56
Багш	20	100,000.00	3,100,000.00	775,000	794,636.62
Шүүх, хууль хяналтын байгууллага	54	20,000.00	3,000,000.00	812,407.41	832,726.67

Тухайн харьцуулсан хүснэгтээс үзэхэд эрүүл мэндийн салбар нэн эрсдэлтэй байгаа нь харагдаж байна. Тухайлбал эрүүл мэндийн салбарт гэхэд удирдах ажилтнаас эмч, сувилагч хүртэлх бүх шатанд 50.0 мянгаас 15.0 сая хүртэлх төгрөгийн албан бус төлбөр төлсөн болохоо иргэд дурджээ. Өмнөх хариултыг хүйсийн байдлаар харьцуулан үзэхэд “Эмэгтэйчүүдийг бодвол эрэгтэйчүүдийн хувьд ямар нэг төрийн үйлчилгээ авахдаа гар цайлгах буюу мөнгө өгөх тохиолдол 5 хувиар илүү байна”. Гэхдээ эмэгтэйчүүд ч энэ үйлдлийг гаргасан байгааг судалгааны үр дүнгээс харж болно.

ШИЙГГЭЭ 4.

Эрүүл мэндийн салбарын авлига гол төлөв эмийн тендертэй холбогддог. Эмнэлгийн салбарт ажиллаж буй хүн бүр л энэ талаар мэддэг. Эмийн тендерт монопол компаниуд өрсөлдөөд эм ханган нийлүүлдэг. Уг нийлүүлж буй эмийн чанарын баталгаажуулалт хийх лаборатори ажиллахгүй байгаа нь ард иргэдийг эрсдэлд оруулж байна. Түүнчлэн Нийгмийн даатгалын газар/хэлтэс дээр иргэний регистрийн дугаараар өөр хүнд хямдралтай эмийг авсан хэргээр манай газар өргөдөл гаргасан. Үүний дагуу шалгалт хийгээд баримтуудын цагдаа руу шилжүүлсэн асуудал гарсан. Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй мэс заслын эмч, эмэгтэйчүүдийн эмч, гэмтлийн эмч авлигад өртөх эрсдэлтэй.

Иргэд өөрсдөө ч өгөх ёстой гэж ойлгосон, эмч нар ч авах ёстой гэж хүлээж авдаг ийм хэвшмэл хандлага байсаар байна.


Эрүүл мэндийн салбарын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Авлигын гэмт хэрэгт холбогдож шүүхээр ял шийтгэгдсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн авлига авсан мөнгөн дүнгээр харьцуулан үзэхэд хамгийн багадаа 290,000₮, хамгийн ихдээ 31,785,000₮-ийн зөрүү харагдаж байна. Эндээс хүйсээс хамаарч авлигын мөнгөн дүн ялгаатай болох нь батлагдаж байна.

Хүснэгт 18. Авлигын мөнгөн дүн, хүйсээр


Хүйс	Түүвэр (n)	Хамгийн багадаа	Хамгийн ихдээ	Дундаж
Эмэгтэй	9	100,000.00	3,215,000.00	1,380,555.5
Эрэгтэй	6	390,000.00	35,000,000.00	16,165,000.0
Эмэгтэй хүйсийн авлига авсан мөнгөн дүнгийн зөрүү		-290,000.00	-31,785,000.00	-14,784,445.0

График 4. Авлигын талаарх туршлага: гар цайлгах буюу хахууль өгөх шалтгаан



Сүүлийн 12 сарын хугацаанд та эсвэл таны гэр бүлийн хэн нэгэн гишүүн ямар нэгэн ажил амжуулж, төрийн үйлчилгээ авахдаа гар цайлгах, мөнгө өгөх тохиолдол гарсан уу? хэмээх асуултын хариултаас үзэхэд, Эрэгтэйчүүдийн хувьд нэхсэн, тэгэх ёстой гэсэн тогтсон ойлголт болон асуудлаас зайлсхийхийн тулд өгдөг гэсэн хариулт өндөр байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд өөрөө хүссэн, чирэгдэл ихтэй байдлыг даван туулахын тулд өгсөн гэсэн хариулт өндөр байв.

График 5. Авлигын талаарх туршлага: айдас, болгоомжлол



Хэрэв өгөөгүй бол Танд ямар эрсдэл учрах байсан бэ? гэсэн асуултад хэрхэн хариулсан байдлаас үзэхэд эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувьд авлига өгөөгүй бол хэрхэх байсан тухай болгоомжлол ойролцоо байв. Онцлог зүйл гэвэл ажилд орох болон ажил төрлөө алдах байсан гэсэн хариултыг эрэгтэйчүүд илүү өгсөн бол, хугацаа алдах байсан гэж эмэгтэйчүүд илүү хариулсан байна.

Чанарын судалгааны хүрээнд хийсэн ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс үзэхэд эмэгтэйчүүд асуудлыг хурдан шийдвэрлэх буюу цаг хожих гэсэн тодорхой шалтгааны улмаас авлига өгөх, албан бус төлбөр төлөх явдал тохиолдож байжээ.

ШИГТГЭЭ 5.

Эмэгтэйчүүд аль болох асуудлыг хурдан шийдэхийн тулд хэн нэгэнд авлига өгдөг. Эмэгтэйчүүдийн авлигад өртөж буй байдал нь жижиг мөнгөн дүн дээр эргэлддэг. Эрэгтэйчүүд шиг өндөр дүнтэй мөнгийг хийх зориг зүрх байхгүй гэж боддог. Өнөөгийн нийгэмд эмэгтэйчүүд ар гэрээ, үр хүүхдээ асрах үүргийг голчлон хийж байна шүү дээ. Нэг ажил амжуулах гэхээр төрийн үйлчилгээ удаан, хүнд сурталтай, бичиг цаас их шаардана гээд л асуудал бодитоор л байна.

Бизнесийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Дээрх судалгааны үр дүнгээс үзэхэд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн авлигын талаарх туршлага буюу чирэгдэл ихтэй байдлыг даван туулах, тэгэх ёстой гэсэн уламжлалыг

дагасан, өөрсдөө хүссэн зэрэг хариултын хувь хэмжээ ихээхэн ойролцоо байна. Харин авлига өгөөгүй бол хэрхэх байсан тухай айдас болгоомжлолын талаарх туршлага харилцан адилгүй байна.

Хүн амын дунд өөрийнхөө эрх ашгийн төлөө, бусдаас түрүүлж илүүг хүртэх гэсэн, ямар нэг зүйл хийхээс буцахгүй хэсэг бүлэг хүмүүс байсаар байна. Эдгээр хүмүүсийн хувьд хүйсээс үл хамаарч авлига өгөх буюу авахаас буцахгүй байдал харагдаж байна.

Чанарын судалгааны үр дүнгээс үзэхэд хүйсийн хувьд эмэгтэй, ахимаг насны, гэрлэсэн олон хүүхэдтэй, дээд боловсролтой, төрийн байгууллагад ажилладаг, өмнө нь ял эдэлж байгаагүй иргэн авлигын хэрэгт холбогдож байна. Гэхдээ шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим системд жижиг авлигын хэрэг нээлттэй, харин өндөр түвшний авлигын хэрэг хаалттай, ил тод биш байгаа нь бүрэн дүүрэн шинжилгээ хийхэд бэрхшээлтэй байв.

Хүснэгт 19. Авлигын гэмт хэрэгт холбогдсон иргэдийн нийгмийн дүр төрх

Үндсэн үзүүлэлт	Дэд үзүүлэлт	Холбогдогч
Нас (n=12)	18-35	2
	36-55	10
Хүйс (n=21)	Эмэгтэй	12
	Эрэгтэй	9
Иргэншил (n=16)	Монгол улсын иргэн	15
	Гадаад улсын иргэн	1
Гэр бүлийн байдал (n=15)	Гэрлэсэн	12
	Салсан	2
	Ганц бие	-
	Бэлэвсэн	1
Ам бүлийн тоо (n=14)	1-3	3
	4-6	9
	7 ба түүнээс дээш	2
Боловсрол (n=13)	Бага	1
	Бүрэн дунд	2
	Дээд	10
Хөдөлмөр эрхлэлт (n=24)	Төрийн албан байгууллага	15
	ААНБ	9
	Тодорхойгүй	1
Ял шийтгэл (n=21)	Эдэлж байсан	3
	Эдлээгүй	17
	Одоо эдэлж байгаа	1

Шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдийн 11 нь ажлын байрны давуу байдлаа ашиглан гэмт хэргийг үйлджээ. Хүйсийн байдлаар нь шинжилгээ хийхэд 9 эрэгтэй байгаагаас


үзэхэд эрэгтэй хүмүүс ихэвчлэн ажлын байрны давуу байдлаа ашиглан гэмт хэргийг үйлддэг байна.

4.4 Авлигын талаарх жендэрийн ялгаатай хэв шинжүүд

Санал асуулгын үр дүнд тулгуурлан үзэхэд авлигын талаар жендэрийн дараах ялгаатай хэв шинжүүд бүрэлдэн бий болж байна. Таны бодлоор жендэр авлигатай тэмцэхэд чухал хувь нэмэр оруулах уу? гэсэн асуултад хариулт өгсөн иргэд, олон нийтийн хариултыг хүйсийн хувьд харьцуулж үзэхэд ойролцоо хариулт өгсөн байлаа. Бүхэлд нь авч үзэхэд иргэд олон нийтийн 23.4 хувь нь авлигатай тэмцэхэд жендэр хувь нэмэр оруулна гэсэн бол, 25.6 хувь нь хувь нэмэр оруулахгүй, 51.0 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан.

Хүйсээр харьцуулсан дүрсээс үзэхэд авлигатай тэмцэхэд жендэр хэр хэмжээтэй хувь нэмэр оруулах талаар эрэгтэй хүмүүсийн 22.8 хувь, эмэгтэй хүмүүсийн 23.8 хувь нь тийм, чухал хувь нэмэр оруулна гэж үзсэн бол эрэгтэйчүүдийн 25.7 хувь, эмэгтэйчүүдийн 25.6 хувь нь ямар нэгэн хувь нэмэр оруулж чадахгүй гэсэн гутранги хариултыг өгсөн байна. Харин эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн энэ талаар хэлж мэдэхгүй хувь ихээхэн ойролцоо(эрэгтэй-51.5 хувь, эмэгтэй-50.6 хувь) байсан болно.

График 6. Авлигын талаар жендэрийн ямар хэв шинжүүд байна вэ?



Авлигатай тэмцэхэд жендэр чухал хувь нэмэр оруулна-(23.4 хувь) гэж үзсэн үндэслэл тайлбарыг энд хариултын давтамжаар авч үзье.

- Ихэвчлэн эрэгтэй хүмүүс өндөр албан тушаалтай болох гэж авлига ихээр өгдөг, авдаг, жендэрийн ялгаа багасахад авлига багасна.
- Авлигатай тэмцэхэд жендэр чухал хувь нэмэр оруулна. Учир нь аль ч салбарт эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг хэрэгтэй.
- Хүмүүсийн хандлага, ажилладаг салбар, хуулийн хариуцлага, шударга ёс, улс төр гээд бүх зүйл нөлөөлнө.
- Хүн бүр нийгмийн харилцаанд оролцдог учраас эрэгтэй ч бай эмэгтэй ч бай бүгд авлигад өртдөг. Хэвшмэл ойлголт өөрчлөгдөхгүй байна, хэвшмэл ойлголтыг багасгаснаар авлигын түвшин буурна.

- Эмэгтэй хүн асуудалд хуулийн дагуу хандана, яагаад гэвэл эмэгтэйчүүд нарийн ширийн зүйлийг сайн ойлгодог, аливаа зүйлд илүү нягт нямбай хандана.
- Эрэгтэйчүүд нийгэмд илүү шийдвэрлэх албан тушаалд ажиллаж байна. Эрэгтэйчүүд нь илүү авлига өгч, аваад байгаа. Тэгэхээр хүйсийн тэгш харьцаатай байвал арай дээр байх болов уу.
- Эрх мэдлийн тэнцвэргүй байдлаас үүдэлтэй, эрх мэдэл эрчүүдэд илүү байгаа тул эрх тэгш оролцоог бий болгох нь чухал.
- Эмэгтэйчүүд боловсрол, эрүүл мэндийн салбарт их, авлигад өртөх магадлалтай.
- Эрэгтэй хүмүүс асуудлыг амраар шийдвэрлэх хандлагатай. Эрэгтэй хүмүүс эмэгтэй хүнийг бодвол шийдэмгий байдаг. Мөн тэр дундаа ганц бие эрэгтэй хүмүүс өртөх хандлага их байдаг.
- Эрэгтэй, эмэгтэй гэлтгүй бүх л хүн авлигатай тэмцэх хэрэгтэй. Зарим тохиолдол эмэгтэй гэдгээрээ дөвийлгөн эрхээ өмнө барьж буруу үйлдэл хийдэг хүмүүс байдаг. Энэ нь нэг талаар буруу ойлголт.

Авлигатай тэмцэхэд жендэр хувь нэмэр оруулахгүй-(25.6 хувь) гэж хариулсан үндэслэл тайлбарт дараах зүйлсийг иргэд дурдсан байна:

- Авлигад хүйс хамаарахгүй, ухамсрын ойлголт,
- Авлига нь жендэрээс хамаарахгүй, ямар ч хүн авлига авч, өгч болно,
- Авлига бол авлига, хувь хүний ёс зүй, хандлага, сэтгэхүйтэй холбоотой,
- Авлигад хүйсийн нөлөөлөл тун бага. Энэ бол том сүлжээ буюу тогтолцоо нөлөөлж байна,
- Авлигад хүйс бус хүнд суртал нөлөөлдөг,
- Аль аль талдаа жендэр хамаарахгүй хувь хүний өгөх болон авах сэдэл байвал жендэр хамаагүй,
- Бүгд л авлига авна. Ядуу нийгэм, дээр нь хүн бүр шуналтай болчихсон,
- Эрэгтэй, эмэгтэй хамаагүй авсан өгсөн хоёр хүн хэрэгцээ шаардлага бий болоод байгаа тул авлига бий болж байна,
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байдал авлигад хамаагүй. Харин албан тушаал, эрх үүрэг үүнд илүү хамаарна.

Дээрх хариултаас үзэхэд авлига нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм дэх эрх, үүргийн ялгаатай байдал, байр суурь, оролцоо, хувь хүний ёс зүй хандлага, сэтгэхүйгээс хамаарч бүрэлдэн бий болох онцлог байна.

Судалгаанд оролцогчид дээр дурдсан салбарт гарч буй авлига чухам ямар үр дагавартай талаар өөрсдийн байр суурийг илэрхийлжээ.

Хүснэгт 20. Таны бодлоор дурдсан салбарт гарч буй авлига ямар үр дагавартай вэ?

	Маш их нөлөөлнө	Нөлөөлнө	Бараг үгүй	Мэдэхгүй
1 Иргэн хүнд материаллаг хохирол учруулна	40.7	38.7	3.3	17.4
2 Хүний эрх зөрчигдөнө	49.8	33.0	2.7	14.5
3 Байгууллагын өмч зүй бусаар завшигдана	40.0	36.1	5.8	18.1
4 Хууль ёс зөрчигдөнө	54.7	27.2	2.7	15.4
5 Ёс зүй, шударга ёс алдагдана	57.5	26.2	2.4	13.9
6 Хүний амь нас, эрүүл мэнд хохирно	42.4	31.5	8.3	17.8
7 Хохирсон хүн байхгүй, аль аль нь хожно	21.4	24.1	23.3	31.1
8 Хүүхэд залуусын ирээдүйн боломжийг хулгайлна	57.6	24.0	4.0	14.4
9 Нийгэмд тэгш бус байдлыг нэмэгдүүлнэ	57.4	24.5	2.7	15.4

Олон нийтийн санал бодлоос үзэхэд авлига бол ёс зүй, шударга ёсыг үгүй хийж (57.5), хууль ёс зөрчигдөхийн (54.7) хэрээр нийгэмд тэгш бус байдлыг нэмэгдүүлж (57.4), цаашилбал хүүхэд, залуусын ирээдүйн боломжийг хулгайлна (57.6) гэжээ.

Энэ бүгдээс үзэхэд авлига бол ойр зуур мэдэгдэхгүй хэр нь үрт хугацаанд ихээхэн уршигтай болох талаар иргэд, олон нийт тэмдэглэжээ. Хожигч нь тухайн үед шийдвэр гаргасан сайд, түшмэлүүд, хохирогч нь нийгмээрээ, бүгдээрээ байдаг. Төрийн бус, иргэний нийгмийн байгууллагын нэгэн эксперт ярилцлагад дараах зүйлийг онцолжээ.

ШИГТГЭЭ 6.


Авлигын хохирогчид ирээдүй хойч үе маань болж байна. Хотын утаа, дэд бүтцийн өнөөгийн байдал, хичээллэх орчин муудах зэрэг хүүхдийн эрх ашиг асар их зөрчигдөж байна. Жилд олон хүн эрсдэж байгаагаас олонх нь хүүхэд байна. Мөн ажилгүйдэл их болж байна. Жижиг дунд бизнес эрхлэгчид банкны зээл авахад нөхцөл их хүнд учир банкнаас зээл авч чадахгүй зэрэг авлигын хор уршгаас болж иргэн хүний амьдрах орчин байхгүй өөрөөр хэлбэл эрх чөлөөтэй ажиллаж амьдарч чадахгүй болж байна.

Бизнесийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Ялангуяа өндөр түвшний авлига ихсэж, газар авснаар улс орны цаашдын хөгжил хохирно. Энэ нь эцсийн дүндээ нийгмийн гишүүн бүр хохирно гэсэн үг хэмээн иргэд үзсэн байна.

Судалгааны хүрээнд иргэн ойр орчмынхоо хүмүүс эсвэл орон нутгийн болон төрийн үйлчилгээ үзүүлдэг цагдаа, хуульч, эмч, багш, төрийн албан хаагчидтай авлигын талаар санал бодлоо хэрхэн хуваалцах буюу мэдээлэх талаар байр суурийг тодруулсан юм.

Дүрс 7. Авлигын талаар санал бодлоо хуваалцах байдал



Тоон судалгааны үр дүнгээс үзэхэд аль ч төрийн албан хаагчидтай авлигын талаар санал бодлоо хуваалцахгүй гэж үзсэн санал бодол 50-иас дээш хувьтай (эмч болон шүүгч дээр илүү өндөр 55.1-55.6 хувь) байна.

Чанарын судалгааны үр дүнгээс үзэхэд авлигын гэмт хэрэгт өртөх байдалд хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Эмэгтэйчүүд илүү байгууллагын түвшинд авлигын хэргийг, харин эрэгтэйчүүд улс төр, хууль эрх зүйтэй холбоотой авлигын гэмт хэргийг үйлддэг болох нь нотлогдсон юм.

Хүснэгт 21. Авлигын шалтгаан, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн материалаар

Эмэгтэй	Эрэгтэй
- Цэцэрлэгийн эмч, цэцэрлэгийн туслах багш, өлгүүрчнээр ажилд авах; - Хугацаа нь дууссан хүнсний бүтээгдэхүүн хадгалж, зарж борлуулсан зөрчил; - Харьяаллын бус иргэдийн хүүхдүүдийг тухайн цэцэрлэгт элсүүлэн суралцуулах; “Айфон-11 про макс” маркийн гар утсыг өөрт холбогдох хэрэгт мэдээ, мэдээллийг өгч, гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийснийх нь хариуд; - Албан тушаалд томилогдох; - Хэргийг хурдан шийдвэрлүүлэх, хохирлыг хурдан шуурхай төлүүлэх ашиг сонирхлын үүднээс буюу албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд;	- Тендерийн сонгон шалгаруулалт; - Гэрчилгээ гаргах; - Бичил уурхай эрхлэх зөвшөөрөл; - Онцгой албан татварын тэмдэг “акц”-г хуурамч баримт бичиг; - Зөрчилтэй татварын тайлан;

Эрэгтэй хүмүүс улс төрийн эрх бүхий албан тушаалтнуудтай ойр дотно болох эсвэл танил талаараа дамжуулан нөөц, ажлын байр болон бусад ашиг тусыг хуваарилахдаа давуу эрх олж авах явдал нийтлэг байна.

Тохиолдол 1. Албан тушаалын наймаа

Иргэн Сүхээ 54 настай, эмэгтэй, одоогоор төрийн байгууллагын газрын даргаар ажилладаг, тухайн орон нутагт 20 гаруй жил амьдарч байна. Гэр бүлтэй, эхнэр, 2 хүүхэдтэй. Том хүү нь тусдаа гарсан. МУБИС-г төгсөөд аймагт хуваарилагдан ЕБС-д багшаар ажлын гараагаа эхлэн багш, сургалтын менежер, захирлын албан тушаалыг гүйцэтгэсэн. Тухайн үеийн боловсролын газрын дарга нь ЕБС-ийн захирлуудыг сэлгэн ажиллуулах замаар хамгийн ойр дотны тойрон хүрээлэгч нарыг төвийн сургуулиудын захирлуудаар томилон ажиллуулж, харин хэл ам ихтэй, шүүмжилдэг захирлуудыг захын сургуулиудын захирлаар томилсон явдлыг хүлээн зөвшөөрөхгүй, маргаан үүсгэсэн юм. Хэн шударгаар ажиллаж, тодорхой үр дүнд хүрч буй хүнийг хавчин шахах замаар ажлаас нь халдаг байдал ч газар авсан. Миний бие тухайн асуудлыг холбогдох газруудад тавьж, шалгалт оруулсан нь шударга үнэний төлөөх миний тэмцэл эхэлсэн гэж болно. Тухайн үеийн аймгийн удирдлагууд олж харж, боловсролын газрын даргаар тавьж ажиллуулсан. Гэвч 2016 оны сонгуулийн дараа гэнэт манай байгууллагад шалгалт орж, 6 төрлийн акт тавьсан нь намайг ажлаас халах үндэслэл болсон. Миний оронд өмнө нь байсан өнөөх дарга нь томилогдоод ирсэн. Судлаад үзсэн аймгийн засаг даргын сонгуулийн компани т ажилд гар бие оролцсоны төлөөх шагнал нь байсан. Албан тушаалын наймааг жинхэнэ утгаараа нүүр тулан биеэрээ амссан. Үүнтэй холбоотой 4 жилийн хугацаанд 3 шатны шүүхээр хэргээ шийдүүлэх гэж явсан.

Орон нутагт хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

4.5 Жендэрийн онцлог ба авлигатай үр дүнтэй тэмцэх нь

Судалгааны үр дүнд тулгуурлан жендэрийн онцлог нөхцөл байдал авлигад тодорхой хэмжээгээр нөлөөлдөг бөгөөд авлигатай үр дүнтэй тэмцэж болох тухай жендэрээс үүдэлтэй дараах саналууд гарч байна. Авлигатай тэргүүн зэрэгт тэмцэх ёстой байгууллага бол Авлигатай тэмцэх газар гэж иргэдийн багагүй хувь болох 18.4 хувь нь үзжээ. Нэг талаас энэ хариулт нь чиг үүргийн байгууллагын хувьд хамаатай боловч төрийн бусад институцээс ихээхэн хамаарч байдаг. Судалгааны талбарт ажиллах явцад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлдэг, төрийн байгууллага бүр авлигатай тэмцэх төлөвлөгөө гарган ажиллаж буй, тухайн байгууллагад эрх бүхий албан тушаалтан ажиллаж байна. Гэхдээ байгууллагын удирдлагын хүсэл зоригоос хамаарч эрх бүхий албан тушаалтныг өөрөө томилох асуудал байна, мөн эрх бүхий албан тушаалтныг чадавхжуулах хэрэгцээ, шаардлага ч байна.

Хүснэгт 22. Авлигатай тэргүүн зэрэгт тэмцэх ёстой байгууллага

		Хариулт	
		N	Хувь
Нэгтгэв	Авлигатай тэмцэх газар	744	18.4
	Улсын Их Хурал	666	16.5
	Хууль хяналтын байгууллага	632	15.7
	Засгийн газар	588	14.6
	Иргэд өөрсдөө	389	9.6
	Салбарын яамд	324	8.0
	Эмнэлгийн байгууллагын удирдлага	309	7.7
	Боловсролын байгууллагын удирдлага	152	3.8
	Төрийн бус байгууллага	103	2.6
	Хараат бус хэвлэл мэдээлэл	116	2.9
	Бусад	11	0.3
	Нийт	4034	100.0

Тайлбар: Хариулт олон сонголттой түл N=1548-тай тэнцэхгүй

Иргэд, олон нийтийн хувьд авлигатай тэмцэх дараагийн чухал байгууллага бол УИХ-16.5 хувь, хууль хяналтын байгууллага-15.7 хувь, Засгийн газар-14.6 хувь гэж үзжээ. Гэвч төрийн байгууллага, ялангуяа институцийн түвшинд зохион байгуулалттайгаа өмчийг хулгайлах, завших явдал ихээхэн байгааг иргэд дурдаж байна. Тухайлбал, бүх төрлийн тендер (ялангуяа ногоон автобусны тендер) зэрэг төрийн томоохон хулгай луйврыг УИХ-ын гишүүд, сайд дарга нар хийж, агаарын бохирдлыг бууруулах төсөл, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, ковид-19 өвчнийг эмчлэх зардал зэрэг нь бүгд өндөр түвшний авлигатай холбоотой бөгөөд илрэхгүй, шийдвэрлэгдэхгүй байгаа нь иргэд, олон нийтийн хувьд асуулт хэвээр байна.

Иргэдийн хувьд авлигыг нэгд улс орны эрх ашгийг хохироох хэмжээний мөнгө, эд зүйлсийг хувьдаа завших, бусдад хууль бусаар эзэмших боломж олгох, хоёрт төрийн албан хаагчийн ёс бус, ёс суртахуунгүй үйлдэл, гуравт төрийн дээд албаны хүмүүс эрх мэдлээ буруугаар ашиглаж буй хэлбэр хэмээн харилцан адилгүй тодорхойлсон боловч энэхүү авлигын улмаас хүмүүсийн эрх ашиг, шударга ёс, үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болохыг тэмдэглэжээ.

Бүх түвшинд үйлдэгдэж буй авлигыг хэрхэн ойлгож, төсөөлж, тодорхойлж байгаагаас хамааран тэдгээрийн авлигыг үл тэвчих, тэмцэх арга хэлбэр илэрхийлэгдэж байна. Нэг талаас төрийн институцэд шударга ёс алдагдсан, нөгөө талаас бүх шатны институцэд итгэх иргэдийн итгэл буурсан өнөөгийн нөхцөлд авлигатай тэмцэх дараагийн чухал субъект бол иргэд өөрсдөө юм-9.6 хувь гэсэн санааг дурдсан байна. Магадгүй, иргэн бүр авлигыг үл тэвчих ухамсартай, хариуцлагатай байх нь эл үзэгдлийг хязгаарлах нэгэн хүчин зүйл байж болох юм.

Хүснэгт 23. Авлигатай тэмцэх бодлогод жендэрийн онцлогийг харгалзах нь

Жендэрийн онцлог	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	
1 Эмэгтэй, эрэгтэй хүмүүс илүү ёс зүйтэй, шударга зарчмыг баримталж ажилласнаар авлигыг бууруулж чадна.	2.26	2.35	2.31	M<F
2 Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлснээр авлига буурна.	1.50	1.73	1.64	M<F
3 Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлснээр төрийн үйлчилгээ чанаржина.	1.47	1.68	1.59	M<F
4 Төрийн өндөр албан тушаалд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлснээр илүү нээлттэй, ил тод засаглалтай болно.	1.54	1.69	1.63	M<F
5 Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэнээр нийгмийн зорилтот бүлгүүдийн эрх ашгийг илүү хамгаална.	1.64	1.87	1.77	M<F
6 Иргэдийн олон нийтийн оролцоо сайжирна.	1.90	2.06	1.99	M<F
7 Авлигын түвшин буурна.	1.61	1.76	1.70	M<F

Тайлбар: М-Эрэгтэй, F-Эмэгтэй

Авлигатай тэмцэх бодлогод жендэрийн онцлогийг харгалзан үзсэнээр тодорхой ахиц дэвшил гарах талаар иргэдийн өгсөн хариултын дундаж үзүүлэлтийг авч үзэхэд жендэрийн онцлогийг харгалзсанаар авлигыг бууруулж, авлигатай тэмцэх бодлогод ахиц дэвшил гарна гэдэгтэй санал нийлж буй эмэгтэйчүүдийн хариултын хэмжээ бүх үзүүлэлтээр эрэгтэйчүүдээс илүү байна. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдэд чиглэсэн дээрх бодлого үр нөлөөтэйн дээр, эмэгтэйчүүдийн хувьд ч хүлээлт, хүсэл эрмэлзэл өндөр байна гэсэн үг юм.

Судалгаанд оролцсон иргэд, олон нийтийн хариултаас үзэхэд дараах хэд хэдэн түвшинд авлигатай тэмцэж болох талаар байр сууриа илэрхийлжээ. Үүнд:

- Авлигаас үүдэн төр засаг “хүчгүйдэж” нэг ёсондоо аюулгүй байдлын үндэс алдагдаж байгаа тул суурь нөхцөлийг сайжруулах, тогтолцооны ил тод байдлыг хангах хэрэгтэй.

Иргэдийн дунд “хавтгайрсан” хэмээн тооцогдож буй дунд болон доод түвшний авлигыг багасгах нэгэн арга зам бол эдийн засгийн бодит боломжид тулгуурлан төрийн албан хаагчдын цалин хангамжийг нэмэгдүүлэх явдал юм. Гэвч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүйсийн үүргийн ялгаатай байдал, жирэмслэх, гэрийн ажил хийх зэргээс хамаарч ажил хөдөлмөр эрхлэх, орлого олох, эдийн засгийн оролцоо бүрэн дүүрэн хангагдаагүйн улмаас шийдвэр гаргах түвшний ялгаатай байдал байсаар байна. Түүнчлэн эдийн засгийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх нь авлигыг өөгшүүлэхгүй байхад нэн тустай. Үүнд

макро эдийн засгийн тогтвортой байдал чухал болно. Мөн иргэд, олон нийт тендерийг цахим болгох, ил тод болгох нь төрөөс завших, хулгайг зогсоох чухал алхам болохыг тэмдэглэжээ.

- **Хууль эрхийн хүрээнд төдийгүй, түүнээс гадуур өргөн хүрээтэй тэмцэхийг санал болгож байна.**

Авлигыг зөвхөн гэмт үйлдэл төдийгөөр хязгаарлан эрүүгийн хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, үүрэг хариуцлагын хүрээнд шийдвэрлэхийг оролдох нь тийм ч өгөөжтэй арга зам биш хэмээн дэлхий нийтийн хандлагад үзэх болсон. Ялангуяа томоохон түвшний авлигатай тэмцэхийн тулд хууль эрхийн орчноо сайжруулах, хэрхэн тэмцэх талаар тодорхой үзэл баримтлалтай байх хэрэгтэй. Авлигатай тэмцэх тогтолцоог бий болгосон, цаашид улам нарийвчлан хөгжүүлэх шаардлагатай. Эмэгтэй хүмүүсийн үйлдсэн авлигыг эмэгтэй хүмүүс хянадаг, мөрдөн шалгадаг болгож төрөлжүүлэх, мөн прокурорын байгууллага, авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хяналт, уялдаа холбоог сайжруулж, чадваржуулах хэрэгтэй.

- **Ихэнх хүмүүсийн ойлгодог шиг “авлигыг тогтсон хууль дүрмийг зөрчих төдийгөөр үзэж болохгүй” тул тогтолцоот байдлаар системтэй тэмцэх нь чухал.**

Учир нь бүх түвшинд авлигыг үйлдэгч нь хууль дүрмийг сайтар мэдэхийн сацуу, хуульд тусгаагүй атлаа улсын эрх ашгийг “илэрхий зөрчсөн” үйлдлүүд гаргах нь олонтоо байдаг. Иймд эл түвшинд үйлдэгдэж буй авлигатай тэмцэхийн тулд нэр томьёог оновчтой болгохоос эхлээд зонхилон үйлдэгдэж буй хэлбэр, хор уршиг, тэмцэх ба илрүүлэх, зохицуулах арга замын талаар холбогдох хуульд зүйл заалт оруулах нь нэгэн чухал алхам болох юм. Хууль эрхийн хүрээнд өндөр түвшний авлигатай тэмцэхдээ макро орчныг сайжруулж авлигыг үл тэвчих үзэл хандлагыг бий болгох, хууль дээдлэхийн зэрэгцээ биелүүлэх, нэгэнт тухайн этгээд авлигын хэрэг үйлдсэн нь тогтоогдсон бол шийтгэх ял тодорхой байх, ял шийтгэлийг чангатгах, эрүүгийн хуулийн зүйл заалтад оноох шийтгэлийг тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна.

- **Дан ганц авлигатай өөртэй нь тэмцэх бус харин макро орчныг сайжруулах замаар бүхий л түвшний авлигатай тэмцэх явдал чухал болно.**

Авлигад өртөх магадлал ихтэй ажлын байрны цалинг нэмэх замаар хариуцлагыг бэхжүүлэх, ажлын ачааллыг бууруулж, орон тоог ихэсгэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай. Тухайн албан тушаалтан авлигад өртсөн тохиолдолд ял шийтгэлийг нь чангаруулах хэрэгтэй. Олон улсын практикаас үзэхэд хууль эрхийн болон улс төрийн авлига нь харилцан бие биеэ нөхцөлдүүлж байдаг. Авлигад өртсөн нь тодорхой болсон ч, “улс төрийн хамгаалалт” бүхий этгээдэд шүүх, хуулийн байгууллага зарим тохиолдолд хариуцлага тооцож чаддаггүй. Энэ байдал нь улс төр, төрийн албанд ажиллах үнэнч шударга иргэдийг шантрах, зайлсхийхэд хүргэдгээрээ цаашилбал хялбар аргаар мөнгөтэй болох гэсэн хүмүүсийг “өдөөж” байдгаараа ихээхэн хор уршигтай, нөгөө талаар авлига авах сонирхол бүхий этгээдийг төрийн албанд орж ирэх “гүүр” болдгоороо үндэсний аюулгүй байдалд заналхийлэл учруулах нэгэн нөхцөл болдгийг үгүйсгэх аргагүй юм.

- Улс төр, эдийн засгийн хандлагаар авлигатай тэмцэх шаардлагатай.

Авлигатай тэмцэх хойшлуулшгүй чухал зүйл бол төрийн бодлого тодорхой, нэгдсэн үзэл хандлагатай, улс төрийн тогтолцоог шинэчлэх, өөрчлөх явдал хэмээн энэ чиглэлийн судлаачид үзсэн байна. Улс төрийн тогтолцоог сайжруулахын тулд нэн тэргүүнд сонгуулийн тогтолцоог өөрчлөх, намын харьяаллаар талцах явдлыг багасгах, намын хамгаалалтад “нуугддаг” байдлыг халах төрд алба хааж буй хүмүүсийг томилох томилгоо, улс төрийн намуудаас хэт хараат байдлыг багасгах зэрэг болно. Эл үйл явц эрчимтэй хийгдэж байгаа нь, нөгөө талаар улс төрийн сонгуульд эмэгтэйчүүдийн квотыг нэмэгдүүлэх замаар шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангах талаар холбогдох хуульд тусгасан нь алс хэтдээ жендэрээс үүдэлтэй авлигыг бууруулахад нөлөөлнө гэж үзэж байна.

- Төрийн албанд захиргааны хяналт тогтоож, хариуцлага, дүрэм журмыг сахиулах байдлаар тэмцэх хэрэгтэй.

Шударга ёсыг сахиулах, нэг ёсондоо ил тод, хараат бус, бие даасан байдлыг хариуцлага, ёс зүйтэй зөв хослуулах нь ихээхэн чухал бөгөөд төрийн албанд дээрх нөхцөлийг хангах нь авлигын эсрэг тэмцэлд нэн тустай. Иргэд төр засагт итгэхээ болих, авлигыг төрийн албанд, дээд түвшинд, эрх мэдэлтнүүд ихээхэн авдаг хэмээх “сэрдлэг” нь авлигыг нийт нийгэм даяар “дэврээж”, улмаар “хүн бүр байх ёстой ердийн зүйл” хэмээн хүлээн авахад хүргэдэг. Иймд авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгэмд бүрдүүлэх, олон нийтийн хяналтыг сайжруулах, төрийн албанд ажиллах эрх тэгш байдлыг хангах, зайлшгүй хянах ёстой албан тушаалтны жагсаалтыг гаргах, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, хянах, мэдээлэх чиг үүрэгтэй эрх бүхий албан тушаалтныг чадавхжуулах нь нэн чухал юм.

- Иргэдийн дунд тогтсон хэвшмэл, буруу үзэл бодлыг мэдээлэлд суурилан арилгах, нөлөөллийн ажил хийх хэрэгтэй.


Прокуророос очсон хэргийг улс төрийн нөлөөгөөр шүүх арай зөөлрүүлж, хойшлуулж байна, хэдэн арван тэрбумаар идсэн хэрэгтэн зүв зүгээр явж байна. Ийм байвал авлигыг үйлдэхэд ямар нэгэн ял авахгүй өнгөрөх юм байна гэсэн ойлголт, иргэдийн дунд их байна. Хэрэв баталгаа нотолгоотойгоор үнэн нь тогтоогдсон бол улсыг хохиролгүй болгох, торгох, төрийн албанд ажиллахыг хязгаарлах, хялбаршуулсан байдлаар шийдвэрлэж буй үндэслэлийг нарийвчлан гаргаж, иргэдэд мэдээлж байх тогтолцоог бий болгох ёстой. Хууль тогтоомжийг олон нийтэд сайтар таниулж үхуулан сурталчлах, гаргасан хуулиа сайтар хэрэгжүүлэх хэрэгтэй.

I ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улс дахь Авлига ба жендэрийн холбоо хамаарал сэдэвт судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна: Үүнд:

Авлига ба жендэрийн харилцан хамаарлын тухайд:

- Судалгааны хүрээнд хийсэн баримт бичгийн судалгаа, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн материалын шинжилгээ, иргэдийн дунд явуулсан санал асуулгын шинжилгээнээс үзэхэд авлига ба жендэр хэмээх үзэгдэл нь шууд (функцийн) хамааралтай биш боловч, зарим нэг уялдаа холбоо, хамаарлын сэжиг байна.
- Ковид-19 цар тахлын дараа Монгол Улсад Авлигын төсөөллийн индекс болон Жендэрийн зөрүүтэй байдлын индексийн аль алин нь нэмэгдэх төлөв ажиглагдаж байгаа нь эдгээр асуудал мөн чанарын хувьд бие биеэ нөхцөлдүүлж байна гэж дүгнэх үндэслэл байна.
- Авлига нь албан тушаал, эрх мэдэлтэй уялдаж, шийдвэр гаргах түвшинд ашиг сонирхлын зөрчлөөр илэрч байдаг үзэгдэл болохын хувьд жендэрээс хамаарсан үүргийн ялгаатай байдалтай нягт уялдаж байна. Жендэрээс үүдэлтэй шийдвэр гаргах түвшин дэх албан тушаалын ялгаатай, эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь авлигын сэдэл, үйлдэл, хэмжээнд нөлөөлж байна. Үүнийг дараах байдлаар зураглан үзүүлж болох юм.



- Боловсрол, эрүүл мэнд, шүүх, хууль тогтоох байгууллага зэрэг авлигад илүү өртөмтгий байгаа салбаруудын хувьд дундаас дээш албан тушаалд эрэгтэйчүүд, харин дундаас доош албан тушаалд эмэгтэйчүүд зонхилох хандлагатай байгаа нь эрэгтэй хүмүүс илүү өндөр түвшний авлигад, эмэгтэй хүмүүс жижиг авлигад илүү өртөмтгий байж болохыг нөхцөлдүүлж байна. Өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо хангалтгүй байгаа нь авлигын

цар хүрээг нэмэгдүүлэхэд ихээхэн нөлөөлж байна. Нөгөө талаар авлигын цар хүрээ нэмэгдэхийн хэрээр ядуурал, жендэрийн тэгш бус байдал нэмэгддэг болохыг олон улсын туршлагаас бид мэдэх билээ.

- Төрийн үйлчилгээний салбаруудаас, эрүүл мэнд, боловсролын салбарын эмч, сувилагч, багш нар авлигад өртөмхий байна. Тухайн салбарт ажиллагсдын дийлэнх олонх буюу 80 орчим хувь нь зонхилон эмэгтэйчүүд байгаа нь үүний суурь нөхцөл болно.
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгааг тайлан дүгнэлт, үндэсний жендэрийн статистикаас шүүн үзэхэд төрийн албан хаагчдын дийлэнх нь эмэгтэй байгаа бөгөөд эзэлж буй хувь хэмжээтэй харьцуулахад авлигын эрсдэл харьцангуй бага байсан юм.
- Судалгааны үр дүн болон статистик тоо баримтаас харахад төрийн албанд шат ахих тусам эрэгтэйчүүдийн тоо хэмжээ нэмэгддэг, эсрэгээрээ эмэгтэйчүүдийн тоо буурч байгаа нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог бууруулж, эрэгтэйчүүд авлигад өртөмхий байхад нөлөөлж байна.
- Баримт бичгийн судалгааны аргын хүрээнд тухайн чиглэлээр бүртгэл дүн шинжилгээ хийж буй байгууллагын өргөдөл, гомдлын мэдээлэл, шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийхээр төлөвлөсөн боловч энэ чиглэлийн хүйсээр ялгасан баримт байсангүй.
- Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд хэргийн ял оногдуулах байдал харилцан адилгүй байна. Эрэгтэй хүмүүст баривчлах ял оноох нь илүү байхад эмэгтэй хүмүүст дүйцүүлэх, тэнсэх ялыг түлхүү өгч байгаа нь ажиглагдав. Нөгөө талаар шүүхийн практикт өндөр түвшний томоохон авлигын шийдвэрлэсэн хэргүүд хүчингүй болсон тохиолдол гарч байжээ.
- Албан тушаал ахих, эд хөрөнгөтэй болох, давуу байдлыг өөртөө бий болгох зэрэг хүчин зүйл авлигыг өдөөх хүчин зүйл болдог. Авлигын талаарх мэдээллийг эрэгтэй, эмэгтэй буюу хүйсээр харгалзахгүй өгдөг болох нь судалгааны үр дүнгээс харлаа.
- Нэг талаас иргэдийн өгөх ёстой гэсэн хэвшмэл үзэл, үйл хэргийг хурдан түргэн бүтээх, ашиг хонжоо олох гэсэн шунахайн сэдэл нь, нөгөө талаас эрх зүйн орчин сүл, байгууллагуудын үялдаа холбоо хангалтгүй, хуулийн хэрэгжилтийг хангах хүсэл эрмэлзэл сүл байгаа нь авлигыг өдөөх хүчин зүйл болж байна.

Жендэрээс үүдэлтэй авлигын ойлголт, төсөөллийн тухайд:

- Судалгааны үр дүнгээс үзэхэд авлигын талаар олон нийтийн дүнд харилцан адилгүй, ялгаатай, зарим талаар зөрчилтэй ойлголт, төсөөлөл түгээмэл байсан ч эрэгтэй, эмэгтэй хүйсээс хамаарсан онцлог гэмээр ялгаа харагдаагүй болно.
- Тухайлбал иргэдийн ойлголт, төсөөллөөр авлига гэж, үйлчилгээг түргэтгэх, хугацаа хожих, оочир дарааллыг алгасахын тулд шан харамж амлах, өгөх явдал (эмэгтэйчүүдийн 44.2 хувь, эрэгтэйчүүдийн 44.8 хувь), бусдын жишгээр мөнгө, эд зүйл өгөхийг хэлнэ (эмэгтэйчүүдийн 41.5 хувь, эрэгтэйчүүдийн 43.1 хувь) гэж үзсэн нь нэн ойролцоо байсан юм.

- Харин ямар нэг үйлчилгээ авсны дараа талархсанаа илэрхийлэх, хоолонд урих, бэлэг өгөх нь байж болох зүйл гэж судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 31.0 хувь, эмэгтэйчүүдийн 34.4 хувь нь тус тус үзсэн байна. Энэ нь үндсэндээ авлигыг өөгшүүлэх буюу авлигыг хүлцэж буйн илрэл болно.
- Авлигын шинжтэй бүхий л үйлдлийн талаарх эмэгтэйчүүдийн ойлголт, төсөөлөл эрэгтэйчүүдээс авлигыг хүлцэх буюу байж болох зүйл гэсэн ойлголт 0.74, ёс зүйгүй үйлдэл гэсэн хувь хэмжээ 1.68 хувиар тус тус өндөр байна. Харин хүнд суртал мөн гэсэн ойлголт, төсөөлөл эрэгтэйчүүдээс 0.4 хувиар, авлига мөн гэсэн ойлголт, төсөөлөл 2.12 хувиар тус тус бага байлаа.
- Олон нийтийн төсөөлөлд тулгуурлан авлигыг авч үзэхэд гар цайлгах, албан бус төлбөр төлөх, хахууль өгөх, хүнд суртлыг багасгах, оочир дарааллыг ахиулах гэх мэт ойлголт хандлага ойролцоо жинтэй, өргөн царатай тааралдаж байлаа.
- Судалгааны хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өгсөн авлига буюу гар цайлгалт, албан бус төлбөрийг ойролцоогоор мөнгөн дүнгээр харьцуулахад дундаж хэмжээ ихээхэн ялгаатай байна. Хүйсийн хувьд аль аль нь авлига, албан бус төлбөр төлдөг бөгөөд, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс хоёр дахин илүү төлбөр төлдөг болох нь судалгааны үр дүнгээс харагдсан юм.
- Мөн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн материалын шинжилгээнээс хүйсээс хамаарч авлигын мөнгөн дүн ялгаатай байгаа нь нотлогдсон бөгөөд эрэгтэйчүүдийн авсан авлигын хэмжээ эмэгтэйчүүдээс 4-10 дахин өндөр байжээ.

Жендэрийн ялгаатай байдал ба авлигын талаарх туршлагын хувьд:

- Сүүлийн 12 сарын хугацаанд төрийн үйлчилгээ авахдаа гар цайлгах, мөнгө өгөх тохиолдол гарсан эсэхийг хүйсийн байдлаар харьцуулан үзэхэд дараах онцлог нөхцөл байдал нийтлэг байсныг энд онцлон тэмдэглэж байна.
- Эмэгтэйчүүдийг бодвол эрэгтэйчүүдийн хувьд ямар нэг төрийн үйлчилгээ авахдаа гар цайлгах буюу мөнгө өгөх тохиолдол 5 хувиар илүү байна.
- Эрэгтэйчүүдийн хувьд нэхсэн, тэгэх ёстой гэсэн тогтсон ойлголт болон асуудлаас зайлсхийхийн тулд өгдөг гэсэн хариулт өндөр байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд өөрөө хүссэн, чирэгдэл ихтэй байдлыг даван түүлахын тулд өгсөн гэсэн хариулт өндөр байлаа.
- Авлига өгөөгүй бол ямар эрсдэл учрах байсан талаар эрэгтэй, эмэгтэйчүүдийн болгоомжлол ойролцоо байсан бөгөөд онцлох зүйл гэвэл ажил олдохгүй, ажил төрлөө алдах байсан гэдэг хариултыг эрэгтэйчүүд, хугацаа алдах байсан гэдэг хариултыг эмэгтэйчүүд илүү өгсөн байна.
- Эмэгтэйчүүдийн бодлоор авлига эрүүл мэндийн салбарт илүү гардаг гэсэн бол, бусад салбарт гардаг гэсэн эрэгтэйчүүдийн байр суурь илүү өндөр байна.
- Дундаж үзүүлэлтийн шинжилгээнээс үзэхэд шүүх хууль, хяналтын байгууллагад гардаг гэсэн хариулт эрэгтэй (3.34), эмэгтэй (3.29) хүмүүсийн хувьд өндөр байна. Бизнесийн салбарын хувьд эрэгтэйчүүдийн байр суурь өндөр (3.02) байхад

эмэгтэйчүүдийн байр суурь арай бага (2.79) байна. Харин боловсролын салбарын авлигын талаар эрэгтэй (2.73), эмэгтэй (2.72) хүмүүсийн байр суурь ойролцоо, дунджаас доогуур байв. Харин банк санхүүгийн авлигын талаар эрэгтэй (2.57) эмэгтэй (2.49) хүмүүсийн байр суурь бусад салбараас харьцангуй доогуур байлаа. Ялангуяа боловсролын салбар дахь авлига өмнөх онуудаас буурч буй нь бүртгэл мэдээллийн цахимжилт, мэдээлэл нээлттэй, ил тод байдалтай үялдаатай байжээ.

- Тэрчлэн судалгааны хүрээнд хууль хяналтын байгууллагын удирдах албан тушаалтанд (7.3), эмчид (7.1) нэлээд хэмжээний мөнгө өгөх явдал гарч байсан гэж мэдээлсэн бөгөөд эрүүл мэндийн салбар илүү өртөмтгий байгаа нь харагдлаа.
- Чанарын судалгааны үр дүнгээс үзэхэд эрүүл мэндийн салбарт гэхэд мэс заслын эмч, гэмтлийн эмч, эмэгтэйчүүдийн эмч нар авлигад өртөмхий байна. Мөн эрүүл мэндийн салбарт, эм ханган нийлүүлэх тендерт авлига зонхилон гарах магадлалтай байгаа нь харагдсан юм.
- Мөн эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн авлигын талаарх түршлага буюу чирэгдэл ихтэй байдлыг даван туулах, тэгэх ёстой гэсэн уламжлалыг дагасан, өөрсдөө хүссэн зэрэг хариултын хувь хэмжээ ихээхэн ойролцоо байна.

Авлигын талаарх жендэрийн ялгаатай хэв шинжийн хувьд:

- Авлига нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм дэх эрх, үүргийн ялгаатай байдал, байр суурь, оролцоо, хувь хүний ёс зүй хандлага, сэтгэхүйгээс хамаарч бүрэлдэн бий болдог онцлогтой.
- Судалгаанаас үзэхэд эмэгтэй, эрэгтэй хүмүүс хүйсийн байдлаас үл хамаарч авлигыг өгч байж ажлаа бүтээдэг гэсэн хэвшмэл үзэл түгээмэл байна. Ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд гэрийн ажил болон гэр бүлийн үүрэг хариуцлагыг өөртөө хүлээдэг нь ажлаа түргэсгэх, цаг хожих зэрэг шалтгаанаар авлига болон албан бус төлбөрийг төлөх үндэслэл болдог байна.
- Эрэгтэйчүүдийн хувьд нэхсэн, тэгэх ёстой гэсэн тогтсон ойлголт болон асуудлаас зайлсхийхийн тулд өгдөг гэсэн хариулт өндөр байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд өөрөө хүссэн, чирэгдэл ихтэй байдлыг даван туулахын тулд өгсөн байна. Үүнээс тогтсон хандлага, жендэрийн дүр, үүрэг авлигад өгөх, авахад нөлөөлж байна гэж үзэх үндэслэл бий.
- Авлигатай тэмцэхэд жендэр хэр хэмжээтэй хувь нэмэр оруулах талаар эрэгтэй хүмүүсийн 22.8 хувь, эмэгтэй хүмүүсийн 23.8 хувь нь тийм, чухал хувь нэмэр оруулна гэж үзсэн бол эрэгтэйчүүдийн 25.7 хувь эмэгтэйчүүдийн 25.6 хувь нь ямар нэгэн хувь нэмэр оруулж чадахгүй гэсэн гутранги хариултыг өгсөн байна. Гэхдээ иргэн бүр авлигыг үл тэвчих ухамсартай, хариуцлагатай байх нь эл үзэгдлийг хязгаарлах нэг хүчин зүйл байж болох юм.
- Олон нийтийн санал бодлоос үзэхэд авлига бол ёс зүй, шударга ёсыг үгүй хийж (57.5), хууль ёс зөрчигдөхийн (54.7) хэрээр нийгэмд тэгш бус байдлыг нэмэгдүүлж (57.4), цаашилбал хүүхэд, залуусын ирээдүйн боломжийг хүлгailна (57.6) гэж дүгнэжээ.

Монгол Улс дахь Авлига ба жендэрийн холбоо хамаарал сэдэвт судалгааны үр дүн, дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг санал болгож байна: Үүнд:

- Судалгаанд хамрагдсан хоёр хүн тутмын нэг нь хүйсээс үл хамааран эрх бүхий ажилтан, албан хаагчид мөнгө, эд зүйлс өгөх явдал гарсан. Иймд дан ганц авлигатай өөртэй нь тэмцэх бус харин макро орчныг сайжруулах замаар, жендэрийн онцлог, ялгаатай байдалд үндэслэн бүхий л түвшний авлигатай тэмцэх явдал чухал байна. Үүний нэгээхэн илрэл бол олон нийтийн хувьд төрийн институт зөвхөн авлигатай тэмцэх бус иргэд өөрсдөө тэмцэх нь чухал болохыг тэмдэглэснээс харж болно.
- Боловсролын салбар дахь авлига өмнөх онуудаас буурч буй нь бүртгэл мэдээллийн цахимжилт, мэдээлэл нээлттэй, ил тод байдалтай уялдаатай байсныг үндэслэн төрийн үйлчилгээний бүх салбарт хүнээс үл хамаарсан мэдээллийн цахимжилт, шударга ёсны ил тод байдал ус, агаар мэт хэрэгтэй байна.
- Олон улсын зөвлөхүүд эмэгтэйчүүд, залуучуудын төлөөллийг авлигатай үр дүнтэй тэмцэж чадна гэдгийг онцолсон. Эмэгтэйчүүдийн хувьд жендэрийн тэгш байдлыг хангаснаар авлигатай тэмцэх бодлого ахиц дэвшил гарна гэж үзсэнийг энд тооцож, зорилтот бүлэгт чиглэсэн холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал юм.
- Авлигын гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн тухай иргэдийн дунд тогтсон хэвшмэл, буруу үзэл бодлыг мэдээлэлд суурилан арилгах, нөлөөллийн ажил хийх хэрэгтэй байна.
- Эрх бүхий албан тушаалтнуудыг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хянаж зөвлөх чиг үүргийн талаар сургаж, чадавхжуулах хэрэгцээ бий.
- Авлигатай тэмцэж буй чиг үүрэг бүхий байгууллагууд цаашид авлигын талаарх өргөдөл, гомдлын мэдээлэл, шийдвэрлэлтийн байдлыг хүйсийн ялгаатай байдлаар гаргах нь чухал юм.
- Авлига ба жендэрийн дүн шинжилгээг цаашид нарийвчлан салбар тус бүрийн онцлогийг харьцуулан судлах шаардлагатай.

I АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Азийн сан, (2018) Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал, Улаанбаатар. <https://asiafoundation.org/publication/бизнес-эрхлэлтийн-орчин-дахь-авлигын/>
2. АТГ, (2024) Авлигын төсөөллийн индексийн 2023 оны үр дүн. Улаанбаатар. <https://www.uih.mn/sudalгаа/s/226>
3. АТГ (2023) Судалгааны тайлан эмхтгэл V боть: Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа, Улаанбаатар.
4. АТГ, (2023, 12 11). Авлигатай тэмцэх газар. <https://iaac.mn/uploads/users/1279/files/V%20boti.pdf>
5. АТГ, (2018). Авлигын шалтгаан, үр дагавар. <https://cdn.greensoft.mn/uploads/site/1152/files/6e396b8e-a4cd-41d6-8a42-535892425542/Avligiin%20shaltgaan,%20hor%20hunuul.pdf>
6. АТГ, (2008) Авлигын ерөнхий төлөв байдлын судалгааны дүн (хураангуй), Улаанбаатар.
7. Батбаатар М ба бусад (2013) Эрүүл мэндийн салбар дахь авлигын шалтгаан, үр дагавар, Улаанбаатар.
8. Давааням О, (2024) Жижиг дунд бизнес эрхлэлт дэх авлигын асуудалд хийсэн социологийн дүн шинжилгээ (барилгын материал худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн жишээн дээр): Улаанбаатар.
9. ЖҮХ, (2023) Монгол улс: Жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин (Сүүлийн үеийн тоо баримтаар), Улаанбаатар. <https://www.ncge.gov.mn/book/монгол-улс-жендэрийн-тэгш-байдлын-өнөөгийн-байдал/>
10. ЖҮХ (2024) Жендэрийн салбар зөвлөлийн тайлан. Улаанбаатар.
11. ЖҮХ (2024) Жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны тайлан. Улаанбаатар.
12. Монголын хуульчдын холбоо, (2023) Шүүх, хууль тогтоох байгууллагын хүний нөөцийн мэдээлэл, Улаанбаатар.
13. МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхим, (2019) Бизнесийн орчин дахь авлигын шалтгаан нөхцөл, Улаанбаатар.
14. Нээлттэй Нийгэм Фрум Оюуны Инноваци ТББ, (2021) Монгол Улсын Шүүхийн Индекс 2021. Улаанбаатар. <https://forum.mn/product/237338>
15. Оюунцэцэг Д., Түмэннаст Г., Батбаатар М ба бусад. (2019). Бизнесийн орчин дахь авлигын шалтгаан, нөхцөл. Социологи, №12 (500), 144-161.
16. УИХ, (2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр) Авлигын эсрэг хууль, Улаанбаатар: <https://legalinfo.mn/mn/detail?lawld=8928>
17. ҮСХ (2023) Монгол улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар, <https://www.1212.mn/mn/statistic/file-library/view/65217112>

18. Цэвэл Я, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар: 2023.
19. ШУТИС (2017) Боловсролын систем дэх авлига, Улаанбаатар. https://www.must.edu.mn/media/uploads/files/zowlomj3_Hi0Xo7r.pdf
20. Шүүхийн Ерөнхий зөвлөл, (2023) Шүүхийн өнөөгийн нөхцөл байдлын тандалт судалгаа. Улаанбаатар. https://www.judcouncil.mn/file/research/2_Шүүхийн%20өнөөгийн%20нөхцөл%20байдлын%20тандалт%20судалгаа.pdf
21. Alexander, Amy C. (2021, July 14). Oxford academic. Alexander, Amy C. (2021, July 14). Oxford academic. <https://academic.oup.com/edited-volume/33431/chapter-abstract/290581792?redirectedFrom=fulltext>
22. Janna Rheinbay, Marie Chêne . (2016). Gender and Corruption topic guide. <https://knowledgehub.transparency.org/guide/guide-3/download>
23. SDC. (2015). Gender analysis in pastoral livestock herding in Mongolia. Retrieved from https://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=&ved=2a-hUKEwi67l65ureEAxVgk1YBHbmCBboQFnoECBYQAQ&url=https%3A%2F%2Fwww.eda.admin.ch%2Fdam%2Fcountries%2Fcountries-content%2Fmongolia%2Fen%2FAFS_Gender_Pastoral_2015_Mongolia.pdf&usg=AOvVaw133KEWfenkp1SOM1D-JKTjd&opi=89978449
24. Sida. (2015). Gender tool box [brief]: Gender and Corruption, <https://cdn.sida.se/publications/files/-gender-and-corruption.pdf>
25. Transparency International. (2024 оны January 30). Corruption perception index 2023. https://images.transparencycdn.org: https://images.transparencycdn.org/images/Report_CPI2023_Eng.pdf
26. Transparency International-Mongolia. (2020 оны May). Mining, Corruption and gender inclusivity in Mongolia. <https://www.osce.org/files/f/documents/4/6/507569.pdf>
27. The World Bank (2023) Global Gender Gap Report 2022. <https://www.weforum.org/publications/global-gender-gap-report-2022/in-full/>

МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГА БА ЖЕНДЭРИЙН ХОЛБОО ХАМААРЛЫН СУДАЛГАА (ИРГЭДЭЭС АВАХ АСУУЛГА)

Судалгааны зорилго

Энэхүү судалгааг Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, АНУ-ын Засгийн газар Төрийн департментын дэргэдэх Олон улсын хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах товчооны санхүүжилтээр МУИС-ийн багш, судлаачид хийж байна. Судалгааны зорилго нь “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал төсөл”-ийн хүрээнд Монгол Улс дахь авлига ба жендэрийн холбоо хамаарлыг тодорхойлж, төрийн байгууллагад чиглэсэн зөвлөмжийг боловсруулахад оршино.

Судалгаанд оролцогчид өгөх зааварчилгаа:

Судлаач нь судалгааны талаарх мэдээллийг оролцогчдод өгөх, мөн судалгаа эхлэхийн өмнө оролцогчийн зөвшөөрлийг заавал авсан байна.

Асуулга 35-40 орчим минут үргэлжилнэ. Манай судлаач танаас асуултуудыг асууж, тодруулга өгөхөд үргэлж бэлэн байх учраас түүнээс тусламж хүсэхдээ бүү эргэлзээрэй.

Мэдээллийн нууцлал, сайн дурын оролцооны баталгаажуулалт:

Таны өгсөн бүх мэдээллийн нууцлалыг Монгол Улсын “Статистикийн тухай хууль” болон “Хувь хүний нууцын тухай хууль”-ийн дагуу чандлан хадгалах болно.

Судалгааны үр дүнг энэхүү судалгаанаас өөр ямар нэгэн зорилгоор ашиглахгүй болно. Таны нэр, нас, хүйс зэрэг хувийн мэдээлэл тань судалгааны үр дүнд дурдагдахгүй.

Таны хариултууд нууцлагдах тул асуултуудад чин шударгаар, бүрэн гүйцэд хариулж тусална уу.

СУДЛААЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ

1	Судлаачийн код	
2	Асуулгын дугаар	
3	Он сар өдөр	
4	Аймаг/нийслэл	Улаанбаатар Орхон Өмнөговь Ховд Дорнод

5	Сум/дүүрэг	Багануур дүүрэг Багахангай дүүрэг Налайх дүүрэг Баянгол дүүрэг Баянзүрх дүүрэг Сонгинохайрхан дүүрэг Сүхбаатар дүүрэг Чингэлтэй дүүрэг Хан-уул дүүрэг
---	------------	---

НЭГ. ХҮН АМ ЗҮЙН ЕРӨНХИЙ ШИНЖ

Энэ хэсэгт таны ерөнхий мэдээллүүдийг тодруулах ба бүх оролцогчдын эдгээр мэдээллийг нэгтгэн боловсруулах тул таны хувийн нууц, дэлгэрэнгүй мэдээллийг танд хамаатуулж тайлбарлахгүйг ойлгоно уу.

1.	Судалгаанд оролцогчийн хүйс (биологийн хүйс)	Эрэгтэй Эмэгтэй Бусад
2.	Нас	_____
3.	Үндэс угсаа	Халх Казах Дөрвөд Буриад Бусад (бичих).....
4.	Шашин шүтлэг	Будда Христ Ислам Бөө Шүтлэггүй Бусад (бичих)
5.	Гэрлэлтийн байдал	Ганц бие Гэрлэсэн Хамтран амьдрагч Салсан/Тусгаарласан Бэлэвсэн
6.	Таны боловсролын түвшин	Боловсролгүй Бага (1-5-р анги) Суурь (6-9-р анги) Бүрэн дунд (10-12-р анги) Техник мэргэжлийн боловсрол Дээд

7.	Таны хөдөлмөр эрхлэлтийн байдал	Байнгын ажилтай Улирлын шинж чанартай ажилтай Түр зуурын ажилтай (хагас цагийн хөдөлмөр) Малчин/дараах асуултыг алгасна уу? Ажилгүй/дараах асуултыг алгасна уу? Тэтгэмж, групп/ХБИ/ Оюутан, сурагч /дараах асуултыг алгасна уу? Бусад (бичих)
8.	Та ямар ажил буюу үйл ажиллагаа эрхэлдэг вэ?	Төрийн удирдах ажилтан Бизнесийн удирдах ажилтан Төрийн албан хаагч Хувийн байгууллагад ажилтан Олон улсын байгууллагад мэргэжилтэн Хувиараа хөдөлмөр эрхлэгч Гэрийн ажилтай Тэтгэвэрт Бусад (бичих).....
9.	Та аль салбарт ажилладаг вэ?	Үйлдвэрлэл Худалдаа Нийтийн аж ахуй Банк, санхүү, даатгал Хөдөө аж ахуй Боловсрол Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал Төрийн захиргаа Төрийн үйлчилгээ Төрийн тусгай алба Бусад (бичих).....
10.	Таны эрхэлдэг албан тушаалын зэрэглэл?	Удирдах албан тушаал/дарга, захирал, эрхлэгч гм. Гүйцэтгэх албан тушаал/мэргэжилтэн, хүний нөөц гм. Туслах албан тушаал/дадлагажигч, үйлчлэгч гм
11.	Таны сарын дундаж орлого	_____
12.	Танай өрхийн орлогын хүрэлцээ?	Өдөр тутмын суурь хэрэгцээнд ч хүрэлцдэггүй (хоол, хүнс гэх мэт) Өдөр тутмын суурь хэрэгцээндээ л дөнгөж хүрдэг Өдөр тутмын хэрэгцээ болон ойр зуурын хувцас хунар зэрэгт л хүрэлцдэг Эдгээрээс гадна үнэ цэнтэй зүйл авчихдаг Хэрэгцээнээсээ илүүчилж хуримтлал бий болгож чаддаг

ХОЁР. АВЛИГЫН ОЙЛГОЛТ, ТӨСӨӨЛӨЛ

13. Таны бодлоор аль салбарт авлига илүү гардаг вэ?/салбарыг үсгийн дарааллаар байрлуулсан/

		Их	Дунд зэрэг	Бага	Байхгүй	Мэдэхгүй
1	Банк санхүү	4	3	2	1	0
2	Боловсрол	4	3	2	1	0
3	Бизнес	4	3	2	1	0
4	Шүүх, хууль хяналтын байгууллага	4	3	2	1	0
5	Эрүүл мэнд	4	3	2	1	0

14. Өмнө дурдсан салбараас ямар нэг үйлчилгээ авахдаа хүмүүс эрх бүхий ажилтан, албан тушаалтанд мөнгө, эд зүйлс өгөх явдалтай тулгарч байсан үү?

Огт таарч байгаагүй	Мэр сэр тааралдаж байсан	Хааяа тааралддаг	Алхам тутамдаа таардаг
1	2	3	4

15. Хэрэв тийм зүйл ажиглагддаг бол үүнийг Та хэрхэн нэрлэх вэ?

1. Шан харамж
2. Гар цайлгалт
3. Албан бус төлбөр
4. Хахууль
5. Авилга
6. Мэдэхгүй

16. Таны бодлоор хүйсийн байдлаар авч үзвэл авлигад хэн илүү өртөмтгий байна вэ?

1. Эрэгтэйчүүд
2. Эмэгтэйчүүд
3. Аль нь ч байж болно
4. Хүйс энд хамаагүй
5. Хэлж мэдэхгүй байна.

17. Дараах тохиолдлуудын алиныг нь Та авлига гэж үзэх вэ?

#	Нөхцөлүүд	Санал огт нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд зэрэг	Санал нийлнэ	Бүрэн санал нийлнэ
1.	Эмэгтэй/эрэгтэй хүн найзынх нь илгээмжийг авчирсан жолоочид мөнгө төлсөн.	1	2	3	4	5
2.	Компанийн төлөөлөгч гаалийн бүрдүүлэлт хийсний дараа гаалийн ажилтанд өөрийнхөө санаачлагаар 1 сая төгрөгийг бэлнээр өгсөн.	1	2	3	4	5

3.	Компанийн санхүү хариуцсан захирал ажилд горилочид ажилд орох санал тавьж, үүний төлөө төлбөр төлөхийг хүссэн.	1	2	3	4	5
4.	Өөрт тулгамдсан асуудлыг танил тал, харилцаа холбоог ашиглан шийдсэнээр ашиг тус хүртсэн.	1	2	3	4	5
5.	Шүүх, хууль хяналтын байгууллагын асуудлаа шийдүүлэх үед эрх бүхий албан тушаалтан бэлэг сэлт, мөнгө өгөхийг санал болгосон.	1	2	3	4	5
6.	Үйлчилгээ тусламжийг бүрэн, чанартай үзүүлсний дараа өвчтөн, түүний ар гэрийнхэн өөрсдөө мөнгө, эд зүйлс өгсөн	1	2	3	4	5
7.	Ямар нэг үйлчилгээ үзүүлэх явцдаа муу үйлчлэх, үйлчилгээг хойшлуулах зэргээр шан харамж, мөнгө авах сонирхолоо илэрхийлсэн	1	2	3	4	5

18. Та дараах тохиолдлуудын талаар ямар бодолтой явдаг вэ?

		Байж болох зүйл	Ёс зүйгүй үйлдэл мөн	Хүнд суртал мөн	Авилгал мөн
1	Бусдын жишгээр мөнгө, эд зүйл өгөх	1	2	3	4
2	Үйлчилгээ авахын өмнө өөрийн санаачлагаар гарыг нь цайлгах	1	2	3	4
3	Үйлчилгээ авсны дараа талархсанаа илэрхийлэх, хоолонд урих, бэлэг өгөх	1	2	3	4
4	Үйлчилгээг түргэтгэх, хугацаа хожих, оочер дарааллыг алгасахын тулд шан харамж амлах, өгөх	1	2	3	4
5	Ах дүү, танил талаа ашиглаж үйлчлүүлэх, үйлчилгээ авах	1	2	3	4

19. Хэрэв дээрх тохиолдолтой таарч байсан бол энэ нь аль салбарт, ямар хүйсийн хүнд тохиолдож байсан бэ? /салбарыг үсгийн дарааллаар байрлуулсан/

#	Байгууллагууд	Зонхилон эрэгтэйчүүд	Зонхилон эмэгтэйчүүд	Аль алинд нь
1.	Банк санхүү	1	2	3
2.	Боловсрол	1	2	3
3.	Бизнес	1	2	3
4.	Төрийн байгууллага	1	2	3
5.	Цагдаа	1	2	3

6.	Шүүх, хууль хяналтын байгууллага	1	2	3
7.	Эрүүл мэнд	1	2	3
8.	Бусад	1	2	3

20. Таны бодлоор дээрх салбарт тохиолдож буй авлигад хэн буруутай вэ?

1. Авлига авсан хүнийг нь
2. Авлига өгсөн хүнийг нь
3. Зуучилсан хүнийг нь
4. Аль алиныг нь
5. Хариулахад бэрхшээлтэй

21. Таны бодлоор жендэр авлигатай тэмцэхэд чухал хувь нэмэр оруулах үү? (Жендэр гэдэг нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ)

#	Хариултууд	Яагаад (бичнэ үү)
	Тийм	
	Үгүй	
	Энэ талаар хэлж мэдэхгүй байна.	

ГУРАВ. АВЛИГЫН ТАЛААРХ ТУРШЛАГА

22. Танд ямар нэгэн ажил амжуулж, төрийн үйлчилгээ авахдаа гар цайлгах, мөнгө өгөх тохиолдол гарсан үү?

1. Тийм
2. Үгүй

23. Хэрэв дээрх зүйл тохиолдож байсан бол санаж буй сүүлийн нэг тохиолдлоо дурдана үү?

.....

.....

24. Та яагаад гар цайлгах, мөнгө буюу хахууль өгсөн бэ?

1. Нэхсэн учраас
2. Тэгэх ёстой гэж хүмүүс ярьдаг учраас
3. Асуудлаас зайлсхийхийн тулд
4. Би өөрөө хүссэн учраас
5. Чирэгдэл ихтэй байсан учраас үйлчилгээг хурдан шуурхай авахын тулд
6. Бусад.....

25. Чухам ямар албан тушаалтан, эсвэл ажилтанд өгч байсан бэ?/мөр бүрт хариулт өгнө/

		Хамт цайлж, жижигхэн бэлгээр гар цайлгах	Томоохон эд зүйл бэлгэлэх	Нэлээд хэмжээний мөнгө өгөх
1	ЕБС-ийн удирдах ажилтан	1	2	3
2	ИДС-ийн удирдах ажилтан	1	2	3
3	Багш	1	2	3
4	Эмнэлгийн удирдах ажилтан	1	2	3
5	Эмч	1	2	3
6	Сувилагч, асрагч	1	2	3
7	Банк, санхүүгийн удирдах ажилтан	1	2	3
8	Банк санхүүгийн гүйцэтгэх ажилтан	1	2	3
9	Шүүх, хууль хяналтын байгууллагын удирдах албан тушаалтан	1	2	3
10	Шүүх, хууль хяналтын байгууллагын гүйцэтгэх ажилтан	1	2	3
11	Бусад	1	2	3

26. Гар цайлгалт, албан бүс төлбөр ойролцоогоор хэдэн төгрөгт багтсан бэ?

.....

27. Хэрэв өгөөгүй бол Танд ямар эрсдэл учрах байсан бэ?/гол гэсэн 2 хариултыг тэмдэглэ/

1. Эрүүл мэндэд хохирол учрах байсан
2. Ажилд орж чадахгүй байсан
3. Ажил төрлөө алдах байсан
4. Ялгавартай хандах байсан
5. Хугацаа алдах байсан
6. Үйлчилгээний чанар муу байх байсан
7. Өөр ямар.....

28. Таны бодлоор авлигын шалтгаан, нөхцөл нь юу вэ?

		Маш их нөлөөлнө	Нөлөөлнө	Бараг үгүй	Мэдэхгүй
1	Төрийн байгууллагад хүнд суртал, чирэгдэл газар авсан	3	2	1	0
2	Байгууллагын ажилтны цалин орлого бага учраас	3	2	1	0
3	Төрийн байгууллагад хяналт шалгалт суларсан үед	3	2	1	0

4	Хүмүүст өгөх ёстой гэсэн хэвшмэл ойлголт байдаг учир гар цайлгах ёстой	3	2	1	0
5	Зохицуулах хууль тогтоомж хэрэгжихгүй байгаа учир	3	2	1	0
6	Үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал учир	3	2	1	0
7	Бүх шатанд шударга ёс алдагдсан	3	2	1	0
8	Бусад	3	2	1	0

29. Таны бодлоор дурдсан салбарт гарч буй авилгал ямар үр дагавартай вэ?
/Мөр бүрт хариулна./

		Маш их нөлөөлнө	Нөлөөлнө	Бага үгүй	Мэдэхгүй
1	Иргэн хүнд материаллаг хохирол учруулна	3	2	1	0
2	Хүний эрх зөрчигдөнө	3	2	1	0
3	Байгууллагын өмч зүй бусаар завшигдана	3	2	1	0
4	Хууль ёс зөрчигдөнө	3	2	1	0
5	Ёс зүй, шударга ёс алдагдана	3	2	1	0
6	Хүний амь нас, эрүүл мэнд хохирно	3	2	1	0
7	Хохирсон хүн байхгүй, аль аль нь хожно	3	2	1	0
8	Хүүхэд залуусын ирээдүйн боломжийг хулгайлна	3	2	1	0
9	Нийгэмд тэгш бус байдлыг нэмэгдүүлнэ	3	2	1	0
10	Бусад	3	2	1	0

30. Та ойр орчмынхоо хүмүүс эсвэл орон нутгийн болон төрийн үйлчилгээ үзүүлдэг цагдаа, хуульч, эмч, багш, төрийн албан хаагчидтай авлигын талаар санал бодлоо хэрхэн хуваалцах буюу мэдээлэх вэ?

		Үргэлж	Заримдаа	Хааяа нэг	Хэзээ ч үгүй
1	Багш	3	2	1	0
2	Эмч	3	2	1	0
3	Захиргааны албан хаагч	3	2	1	0
4	Шүүгч	3	2	1	0
5	Цагдаа	3	2	1	0
6	Бусад	3	2	1	0

31. Таны бодлоор дээр дурдсан салбарт гарч буй авилгалтай тэргүүн зэрэгт тэмцэх ёстой субъект юу вэ? /хамгийн гол гэсэн 3 хариултыг дугуйлна уу/?

1. Улсын Их Хурал
2. Засгийн газар
3. Салбарын яамд

4. Авлигатай тэмцэх газар
5. Хууль хяналтын байгууллага
6. Эмнэлгийн байгууллагын удирдлага
7. Боловсролын байгууллагын удирдлага
8. Эмч, багш, ажилтнууд
9. Мэргэжлийн хяналтын газар
10. Төрийн бус байгууллага
11. Хараат бус хэвлэл мэдээлэл
12. Иргэд өөрсдөө
13. Бусад.....

32. Авлигатай тэмцэх бодлогод жендэрийн онцлогийг харгалзан үзсэнээр тодорхой ахиц дэвшил гарах талаар дараах байр суурь бий. Та өөрийн байр суурь, саналаа илэрхийлээрэй.

#	Жендэрийн онцлог	Санал огт нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд зэрэг	Санал нийлнэ	Бүрэн санал нийлнэ
1.	Эмэгтэй, эрэгтэй хүмүүс илүү ёс зүйтэй, шударга зарчмыг баримталж ажилласнаар авлигыг бууруулж чадна.	1	2	3	4	5
2.	Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлснээр авлига буурна.	1	2	3	4	5
3.	Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлснээр төрийн үйлчилгээ чанаржина.	1	2	3	4	5
4.	Төрийн өндөр албан тушаалд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлснээр илүү нээлттэй, ил тод засаглалтай болно.	1	2	3	4	5
5.	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэнээр эмэгтэйчүүд, нийгмийн зорилтот бүлгүүдийн эрх ашгийг илүү хамгаална.	1	2	3	4	5
6.	Иргэдийн олон нийтийн оролцоо сайжирна.	1	2	3	4	5
7.	Авлигын түвшин буурна.	1	2	3	4	5

Цаг гарган судалгаанд оролцсон танд баярлалаа!